



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 5 ДУГААР САРЫН 07-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 5 дугаар сарын 07-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-23
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	24-76

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх	24-27
1. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	27-31
2. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	31-39
3. Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	40-72
4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлт /Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	72-75
5. Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал	75-76

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
5 дугаар сарын 07-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: Ж.Алдаржавхлан, Х.Баасанжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, А.Ганбаатар, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалан, С.Зулпхар, М.Мандхай, Г.Очирбат, Ч.Ундрал, Л.Энхнасан, С.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Ж.Баярмаа, Х.Ганхуяг, М.Нарантуяа-Нара, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Мөнхтулга, Б.Тулга, С.Цэнгүүн;

Тасалсан: Ц.Мөнхбат;

Хоцорсон: Д.Амарбаясгалан-39 минут, С.Амарсайхан-2 цаг 20 минут, О.Амгаланбаатар-10 минут, Ч.Анар-07 минут, Д.Батбаяр-17 минут, Ж.Батжаргал-03 минут, Х.Баттулга-06 минут, Б.Батцэцэг-10 минут, Э.Батшугар-15 минут, Б.Бейсен-35 минут, Х.Булгантуяа-10 минут, Ш.Бямбасүрэн-43 минут, Д.Ганбат-08 минут, П.Ганзориг-06 минут, Л.Гантөмөр-51 минут, Т.Доржханд-1 цаг 03 минут, Б.Жавхлан-2 цаг 05 минут, Д.Жаргалсайхан-39 минут, Г.Лувсанжамц-02 минут, Л.Мөнхбаатар-01 минут, Л.Мөнхбаясгалан-06 минут, Ч.Номин-06 минут, Н.Номтойбаяр-01 минут, Р.Сэддорж-28 минут, Ц.Туваан-03 минут, Г.Тэмүүлэн-01 минут, А.Ундраа-1 цаг 22 минут, Д.Цогтбаатар-06 минут, Ж.Чинбүрэн-08 минут, Б.Чойжилсүрэн-10 минут, Ж.Энхбаяр-20 минут, Р.Эрдэнэбүрэн-1 цаг 42 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт 5 дугаар сарын 07-нд төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Засгийн газраас 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин нарын 6 гишүүнээс 2026.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороонд;

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 2 гишүүн ирцэд нэмэгдсэн.

Монгол Улсын Засгийн газраас 2026.05.01-ний өдөр өргөн мэдүүлсэн “Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал нарын 40 гишүүнээс 2026.04.26-ны өдөр өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль зүйн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн нарын 21 гишүүнээс 2026.05.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатараас 2026.05.06-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв.

Хуулийн төсөл татан авах талаар танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2025.07.04-ний өдөр өргөн мэдүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3-т заасны дагуу хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцов./10:09/

Нэг. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн тавьсан асуултад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга хариулж, тайлбар хийв.

С.Бямбацогт: Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	65
Татгалзсан:	27
Бүгд:	92

70.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл, П.Наранбаяр, Да.Цогтбаатар нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул хуралдааны тэмдэглэлд саналаа дэмжсэнээр тэмдэглүүлэх санал гаргаж, 74.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч С.Жаргалсайхан, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Б.Батбаатар, Б.Пүрэвдорж, М.Ганхүлэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтэн

шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга Б.Алтантулга, мөн албаны зөвлөх П.Батчулуун нар хариулж, тайлбар хийв.

С.Бямбацогт: Байнгын хорооны саналаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 47

Бүгд: 98

52.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 4 гишүүн 2025.03.31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын төрөлжсөн мэргэшлийн тусламж хариуцсан ахлах шинжээч М.Оюунчимэг, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Үйлдвэрлэлийн тасгийн технологич их эмч Н.Халиун, мөн төвийн Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга Э.Тунгалагтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Г.Анар-Эрдэнэ, референт Ц.Долгормаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, Л.Соронзонболд, М.Энхцэцэг, Ж.Галбадрах, Г.Ганбаатар, М.Ганхүлэг, Ж.Батсуурь, С.Одонтуяа, Б.Бейсен нарын тавьсан асуултад Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр хариулж, тайлбар хийв.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Б.Баярбаатар, Л.Энхнасан, Х.Болормаа, Д.Рэгдэл, У.Отгонбаяр, М.Сарнай, С.Эрдэнэбат /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилгоор сайн дураар цусаа үнэ төлбөргүй өгөх болон цусны донорын үйл ажиллагаа, цусны аюулгүй байдал, бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 43
Бүгд: 102
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан үг хэлж, хуралдаан даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилтын хүрээнд цусны донорын үйл ажиллагааг зохион байгуулах, цусны аюулгүй байдлыг хангах, цус сэлбэлт судлалын салбарын бодлого, удирдлага зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэнд, амийг аврах зорилгоор цус сэлбэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 39
Бүгд: 103
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “цус” гэснийг “цус, цусны бүрэлдэхүүн хэсэг” гэж, мөн заалтын “аюулгүй байдлыг хангахтай” гэснийг “аюулгүй байдал, сонор сэрэмжийн тогтолцоотой” гэж өөрчилж, мөн зүйлийн 3.1.2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 40
Бүгд: 103
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.4 дэх заалт нэмэх:

“3.1.4.“цусны байнгын донор” гэж жилд тогтмол хоёр ба түүнээс дээш удаа цусаа өгсөн хүнийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 43
Бүгд: 103
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах зорилгоор” гэснийг, мөн зүйлийн 3.1.8 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 41
Бүгд: 103
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “биобэлдмэл” гэснийг “бэлдмэл” гэж, мөн заалтын “цус, цусны бүрэлдэхүүн хэсгээс” гэснийг “цусны сийвэнгээс” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 3.1.10 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх:

“3.1.12.“цусны сонор сэрэмжийн тогтолцоо” гэж цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг авах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх явцад гарах сөрөг урвал, хүндрэлийг илрүүлэх, шуурхай арга хэмжээ авах, сэргийлэх цогц үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтыг хасах:

“4.1.3.чанар, аюулгүй байдлыг хангах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн хоёрдугаар бүлгийн нэрийн “ТОГТОЛЦОО” гэснийг “УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ” гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдал, цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай холбоотой төрийн хяналтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллага хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 40
Бүгд: 103
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “, цусны биобэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэх” гэснийг хасаж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 41
Бүгд: 103
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “төрийн бодлогыг Улсын Их Хурлаар батлуулах,” гэснийг “бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн” гэж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын “санхүүжилтийг” гэснийг “түүнтэй холбогдон гарах санхүүжилтийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “гамшгийн” гэсний дараа “болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хэмжээ” гэснийг “албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг” гэж өөрчилж, мөн заалтын “, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ хэрэгжүүлэх” гэснийг, мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 40
Бүгд: 103
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг бүхэлд нь хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 38
Бүгд: 103
63.1 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “үйл ажиллагааг зохицуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.2.цусны донорын үйл ажиллагааны талаар баримтлах бодлого боловсруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 39
Бүгд: 103
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “батлах” гэснийг “баталж, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, мөн зүйлийн 8.1.5 дахь заалтын “орц, илчлэгийн жишиг” гэснийг “зардлын” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 41
Бүгд: 103
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “нэмэгдэл цалингийн хэмжээ,” гэснийг “цалин, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл,” гэж, мөн заалтын “санал боловсруулах” гэснийг “талаар санал

боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 40
Бүгд: 103
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг 8.1.7, 8.1.8 дахь заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.7.цус сэлбэлт судлалын салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх;

8.1.8.цусны донорын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх болон өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэндийг дэмжих санд тусгах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 37
Бүгд: 103
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дахь хэсэг нэмэх:

“8.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 39
Бүгд: 103
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “хуулийн 15.1.12-т” гэснийг “хуульд” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 36
Бүгд: 103
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтын “цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүн, зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоо” гэснийг, мөн заалтын “удирдлага, зохион байгуулалт” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 37
Бүгд: 103
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын “сурталчилгааны ажлыг” гэснийг “сурталчилгаа, донорын эгнээг өргөжүүлэх ажлыг” гэж өөрчилж, мөн заалтын “, цусны донор элсүүлэх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 36
Бүгд: 103
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь заалтын “биобэлдмэл” гэснийг “бэлдмэл” гэж, мөн зүйлийн 9.3.7 дахь заалтын “талаарх магадалгаа” гэснийг “тухай тодорхойлолт” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 9.3.8 дахь заалтын “байгууллага” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 36
Бүгд: 103
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.3.9.энэ хуулийн 20.1-д заасан донорыг Засгийн газрын шагнал болон бусад шагналд нэр дэвшүүлэх саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69
Татгалзсан: 34
Бүгд: 103
67.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.3.10 дахь заалт нэмэх:

“9.3.10.цусны байнгын донорт тэмдэг олгох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 36
Бүгд: 103
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.10 дахь заалтын “бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх” гэснийг “аюулгүй байдлын талаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.3.11 дэх заалтын “улсын хэмжээнд нэгтгэх” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 37
Бүгд: 103
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 38
Бүгд: 103
63.1 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.4.Цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлд шаардагдах төсвийн зардлаа жил бүр улсын төсөвт тусгуулахаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.5.Цус сэлбэлт судлалын асуудлыг хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь дараах байгууллагатай хамтран ажиллана:

- 9.5.1.эрүүл мэндийн байгууллага;
- 9.5.2.төрийн болон төрийн бус байгууллага;
- 9.5.3.аж ахуйн нэгж, байгууллага.

9.6.Хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 35
Бүгд: 103
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.3, 15.1.5, 15.1.6, 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллага цусны донорын үйл ажиллагаанд оролцоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 41
Бүгд: 103
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Энэ хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд цусны донорын үйл ажиллагаа, цусны чанар, аюулгүй байдлыг хангах, журам, стандарт, зааврыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 37
Бүгд: 103
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “донор элсүүлэх” гэснийг хасаж, мөн заалтын “тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд” гэснийг “цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 35
Бүгд: 103
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.2.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 35
Бүгд: 103
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

34.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 37
Бүгд: 103
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, ажил

олгогчийн эрх, үүрэг” гэснийг “Цусны донорын үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 39
Бүгд: 103
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “байгууллагын албан тушаалтан ажил олгогч нь” гэснийг “болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж” гэж, мөн зүйлийн 12.1.3 дахь заалтын “магадалгааг” гэснийг “тодорхойлолтыг” хийж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 36
Бүгд: 103
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4 дэх заалт нэмэх:

“12.1.4.цусны донорын үйл ажиллагааны талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 41
Бүгд: 103
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 39
Бүгд: 103
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн даатгал” гэснийг хасаж, “хамт олон, иргэн,” гэсний дараа “олон улсын байгууллагын” гэж нэмж, төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь өөрийн орлого, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдсэн санхүүжилтийг Эрүүл мэндийн тухай хуулийн 24.5-д заасны дагуу зарцуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 37
Бүгд: 103
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсгийг бүхэлд нь тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 38
Бүгд: 103
63.1 хувийн саналаар дэмжигдлээ.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.6.Цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 35
Бүгд: 103
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн “Цусны албаны нэмэгдэл цалингийн хэмжээг” гэснийг “Энэ хуулийн 13.6-д заасан нэмэгдэл олгох журмыг эрүүл мэндийн болон” гэж, мөн хэсгийг “тогтооно” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 36
Бүгд: 103
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийн “СЭЛБҮҮЛЭГЧ,” гэснийг хасаж, төслийн 14, 17 дугаар зүйлийг нэгтгэн 14 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14 дүгээр зүйл.Цусны донорт тавигдах шаардлага, түүний эрх, үүрэг

14.1.Цусны донор дараах шаардлагыг хангасан байна:

14.1.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ сайн дураар, авлагагүйгээр өгөхийг зөвшөөрсөн байх;

14.1.2.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байх;

14.1.3.эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

14.2.Цусны донор дараах эрхтэй:

14.2.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөнтэй холбоотой гарч болзошгүй сөрөг урвалын талаар мэдээлэл, зөвлөгөө авах;

14.2.2.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх ажилд сайн дураар оролцох;

14.2.3.хуульд заасан бусад.

14.3.Цусны донор дараах үүрэгтэй:

14.3.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 18.2.7-д заасан мэдээллийг холбогдох эмнэлгийн мэргэжилтэнд үзүүлэх;

14.3.2.өөрийн эрүүл мэндийн байдлыг асуумжийн дагуу үнэн зөв мэдээлэх;

14.3.3.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгөхийн өмнөх үзлэг, шинжилгээнд хамрагдах;

14.3.4.эмнэлгийн мэргэжилтний өгсөн зөвлөмжийг мөрдөх;

14.3.5.хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 36

Бүгд: 103

65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15, 16, 18 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

15.1.Иргэний амийг аврах, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэхдээ сэлбүүлэгч эрх зүйн бүрэн чадамжтай бол өөрөөс нь, хүүхэд болон эрх зүйн бүрэн чадамжгүй сэлбүүлэгчийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бичгээр зөвшөөрөл авсан байна.

15.2.Энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авахдаа цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх шаардлага, сэлбэх явцад гарах үр дагаврын талаар сэлбүүлэгчид урьдчилан танилцуулсан байна.

15.3.Амь тэнссэн үед, эсхүл энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авах боломжгүй тохиолдолд холбогдох журам, зааврыг баримтлан цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэнэ.

15.4.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

15.5.Хуульд заасан бусад.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 40
Бүгд: 103
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19, 20, 21 дүгээр зүйлийг нэгтгэн 19 дүгээр зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“19 дүгээр зүйл.Цусны донорын үйлсийг сурталчлах, урамшуулах, дэмжлэг үзүүлэх

19.1.Монголын улаан загалмай нийгэмлэг болон төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын хөдөлгөөнийг сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулна.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан байгууллага болон албан тушаалтан, иргэн нь цусны донорыг элсүүлэх, сургалт, сурталчилгаа явуулахад цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ.

19.3.Цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаанд сайн дурын ажилтныг оролцуулж болно.

19.4.Цусны донорыг “Цусны хүндэт донор” цол тэмдгээр дараах шалгуурын дагуу шагнаж, алдаршуулна:

19.4.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 50 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.4.2.цусаа 35 болон түүнээс дээш удаа өгсөн;

19.4.3.ховор бүлгийн цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ 25 болон түүнээс дээш удаа өгсөн.

19.5.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг, тусламжийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага үзүүлж болно.

19.6.Цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн донорт илчлэг нөхөх хүнсний бүтээгдэхүүн, эсхүл хоолоор үйлчилнэ.

19.7.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор магадлан итгэмжлэгдсэн дотоодын рашаан сувилалд Засгийн газраас тогтоосон сувиллын жишиг үнийн дагуу жилд нэг удаа сувилуулна.

19.8.Энэ хуулийн 19.7-д заасан дэмжлэгийг Ахмад настны тухай хууль, бусад хууль тогтоомжид заасан дэмжлэгтэй давхардуулан олгохгүй.

19.9.Энэ хуулийн 19.7-д заасан дотоодын рашаан сувилалд жилд нэг удаа жишиг үнийн дагуу сувилуулах журмыг гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.10.“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хүндэт донор”, “Монголын улаан загалмай нийгэмлэгийн хүндэт донор” цол тэмдэгтэй иргэнд энэ хуулийн 19.7-д заасан дэмжлэг хамаарна.”

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “тээвэрлэх үйл ажиллагааг” гэсний дараа “Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.7, 15.1.12-т заасан” гэж нэмж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 22.3 дахь хэсэг нэмэх:

“22.2.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.7, 15.1.12-т заасан эрүүл мэндийн байгууллага нь цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах, шинжлэх, боловсруулах зориулалтаар тусгайлан тоногдсон тээврийн хэрэгслийг ашиглан энэ хуулийн 22.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж болно.

22.3.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнагдсан донор нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчино.”

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “гүйцэтгэж болно.” гэснийг “гүйцэтгэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.4, 22.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 45
Бүгд: 103
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “зүйлийн 22.5 дахь хэсэгт заасан” гэснийг “хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн” гэж, тус заалтын “цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан” гэсний дараах “тусгай мэргэжлийн төвд” гэснийг “эрүүл мэндийн байгууллагад” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 45
Бүгд: 103
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.7, 22.8 дахь хэсгийг нэгтгэн 22.7 дахь хэсэг болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.7.Цус, цусан бүтээгдэхүүнийг Эрүүл мэндийн тухай хуулийн 37.3-т заасан журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийн “биобэлдмэлийг” гэснийг “цусны бэлдмэлийг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “байдлын хувьд баталгаажсан” гэснийг “байдлыг хангасан” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 40
Бүгд: 103
61.2 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “онцгой” гэснийг “ноцтой” гэж өөрчилж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах ажлыг улсын хэмжээнд гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба, тодорхой нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед орон нутгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.3, 24.4, 24.5 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 41
Бүгд: 103
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “24.1, 24.3, 24.5-д заасантай” гэснийг “24.1-д заасан зохион байгуулалттай” гэж, мөн хэсгийн “холбоотой зардлыг” гэсний дараах “Засгийн газрын нөөц сангаас” гэснийг “Гамшгийн тухай хуулийн 51.4-т заасны дагуу” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 43

Бүгд: 103
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийн “сангийн” гэснийг “сан байгуулах, ажиллах” гэж өөрчилж, мөн хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараах “асуудал эрхэлсэн” гэснийг хасах:

“25.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор цусны донорын мэдээллийн сантай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 41
Бүгд: 103
60.2 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.3, 25.4, 25.5 дахь хэсгийг тус тус хасах.

Хуралдаан даргалагч дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 43
Бүгд: 103
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн гарчгийн “Цусны донорын үйл ажиллагааны журмыг зөрчигчдөд” гэснийг “хууль зөрчигчид” гэж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг “Төрийн албаны тухай” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 39
Бүгд: 103
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.1 дэх хэсгийг нэмэх:

“28.1.Энэ хуулийн 6.1.6, 8.1.5, 9.4, 13.6-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлтэй холбоотой хэсэг, заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 42
Бүгд: 103
59.2 хувийн саналаар дэмжигдлээ.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 43
Бүгд: 103
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг, заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66
Татгалзсан: 37
Бүгд: 103
64.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 39
Бүгд: 103
62.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 43
Бүгд: 103
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дуусаав.

Цусны донорын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хуулийн төслүүдийг хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./12:57/

Цусны донорын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлт /Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлтийг Цэцийн гишүүн О.Мөнхсайхан танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлттэй танилцлаа.

Уг асуудлыг 13 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./13:09/

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ж.Батжаргал нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 12^а, 12^б ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн 12^а ангийн багш, сурагчид, Завхан аймгийн Цэцэн-Уул сумын иргэд, малчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргалын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Монгени” сургуулийн 12^е ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар Сүхбаатар дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сувилагчдын төлөөлөл, нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн хөтөч” сургуулийн 12^г ангийн багш, сурагчид, Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Ногоон байгаль” эко клубын сурагчид, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн урилгаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлага болон орон нутгийн Төрийн өмчийн газрын мэргэжилтнүүд, Нийслэлийн ерөнхий боловсролын “Хишиг” сургуулийн 9^а, 9^б ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 09 минут үргэлжилж, 126 гишүүнээс 103 гишүүн хүрэлцэн ирж, 81.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

2026 оны 5 дугаар сарын 7-ны /Пүрэв гараг/-ийн чуулганы нэгдсэн хуралдааны ирцийг танилцуулъя. 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 55 хувийн ирцтэй байгаа учраас чуулганы хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнгөрсөн 7 хоногийн Байнгын хороодоор хэлэлцэх асуудлаас дараах асуудлууд хойшлогдсон байна.

1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан/ Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжингийн гаргасан горимын саналын дагуу дэмжигдэн хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдаж байна.

Энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотой хуулийн хугацаатай асуудал. Энийг бас хуулийн хугацаанд нь хэлэлцэх ёстой шүү гэдгийг гишүүддээ сануулъя. Ажлын хэсэг, Хууль зүйн байнгын хороо анхааралдаа аваарай.

2. Дэд хорооны бүрэлдэхүүний асуудал Хууль зүйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны явцад Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатарын гаргасан горимын санал дэмжигдэж, хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хасагдсан.

3. “Хог хаягдлын эрх зүйн орчныг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны явцад тогтоолын төсөл хэлэлцэхийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Тийм учраас бусад асуудлуудыг өнөөдрийн чуулганаар хэлэлцэнэ. Бусад төлөвлөгдсөн асуудлуудыг.

Төрсөн өдөр нь тохиож буй гишүүд 5 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал төржээ. Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал Танд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Баасанжаргал гишүүн маань гадаадад томилолттой байгаа бас гадаад томилолттой ажиллаж байгаа учраас өнөөдрийн чуулганд хүрэлцэн ирээгүй байна.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд эртэч гишүүд Нацагдоржийн Батсүмбэрэл, Оюунсайханы Алтангэрэл, Даваагийн Цогтбаатар, Өлзийхүүгийн Шижир, Болдын Уянга нар хамгийн эрт ирцдээ орсон байна. Эртэч гишүүддээ бас баяр хүргэе.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар дараах 5 асуудлыг хэлэлцэнэ.

1 дүгээрт нь “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. /Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан тогтоол байгаа.

2 дугаарт нь Засгийн газрын тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Мөн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан.

3 дугаарт нь Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн нарын 4 гишүүн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг явуулна. Зарчмын зөрүүтэй 62 саналтай. Өнөөдөр энэ саналуудаар санал хураалт явуулна. Гишүүдийг бас санал хураалт явах үед чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцож, саналаа өгөхийг хүсэж байна.

4 дүгээрт нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ. Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

5 дугаарт нь “Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасан. Үүний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Конвенц соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газар 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин нарын 6 гишүүн 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

3.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хороонд;

4.“Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газар 2026 оны 5 дугаар сарын 1-ний өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

5.“Хянан шалгах түр хороо байгуулах” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Баасанжаргал нарын 40 гишүүн 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

6.Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн нарын 21 гишүүн 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд;

7.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Батын Батбаатар 2026 оны 5 дугаар сарын 6-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д “хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатад санаачилсан хуулийн төслөө татан авч болно.” гэж, 32.3-т “хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль ч шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөөр татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөөр татан авсанд тооцно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдөр хуулийн төсөл татан авах тухай Улсын Их Хурлын 3/4901 дугаартай албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулья.

Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт танаа

Хуулийн төсөл татан авах тухай

Улсын Их Хурлын гишүүн миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Гэвч дээрх хуулийн төслүүдийг дахин нягтлан судлах, боловсронгуй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн тул Улсын Их Хурлын чуулганы

хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийг Улсын Их Хурлын хэлэлцэх асуудлын дарааллаас хасаж, буцааж татсанд тооцож өгөхийг хүсье.

Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан гэсэн бичиг ирүүлсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлангаас 2025 оны 7 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг татан авсанд тооцлоо.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Жигжидийн Батжаргал нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ерөнхий боловсролын 12^б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилт хүсье. Тэгээд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс удахгүй болох гэж байгаа элсэлтийн ерөнхий шалгалтдаа амжилттай, сайн бэлдэж, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, суралцаж, төгсөж, улс эх орондоо хэрэгтэй, ихийг хийж бүтээсэн зөв хүн болж төлөвшихийг хүсье. Аав ээж, багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай хүүхдүүд.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржзовдын Энхтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Д.Энхтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн, Алдаржавхлан, Ариунзаяа, Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Энхнасан Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төслийн хүрээнд байгуулагдах Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төв болон Улсын 1 дүгээр төв эмнэлгийн хашаанд баригдаж байгаа Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн чиг үүргийн ялгааны талаар асуулт асууж, хариулт авлаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбатаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу анхны хэлэлцүүлгээр эцэслэн батлах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

“Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Энхтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн ажлын хэсэг. Намжилдоржийн Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрдэнэбаяр дарга яасан бэ. Мэндсайханы Наранпүрэв Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Сэмбэддоржийн Жаргалсайхан Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Баяраагийн Алтантулга Эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга, Пандааны Батчулуун Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны зөвлөх.

Ажлын хэсгийн гишүүдэд хууль танилцуулъя.

Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д “нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон холбогдох албан тушаалтан үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.” 21.25-д “Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийн танилцуулсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах бөгөөд мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгөх, танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно.” 21.31-д “чуулганы хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүй хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд хуралдааны дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож, тухайн этгээдэд Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэж тус тус заасан байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон ажлын хэсгийн гишүүдийн дотроос Төрийн нарийн бичгийн даргыг ирэхийг хүсэж байна. Ирүүлээрэй.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Асуултаа татаад авчихъя.

С.Бямбацогт: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэрээ татлаа. Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Тэгэхээр маш чухал хууль батлагдлаа. Ер нь Монгол Улсад бол эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ, үйлчилгээг зохицуулах бие даасан хууль бол өнөөдрийг хүртэл байгаагүй. Тийм учраас маш чухал хуультай болж байна. Дээрээс нь анагаахын шинжлэх ухааны хувьд бас шинэ шатад гарах, амьгүй донорыг эд, эс, эрхтэн шилжүүлэх хуульд тусгаж байгаа гээд маш олон хүний амь аврах ийм чухал хууль батлагдаж байгаад баяртай байна. Энэ салбарынханд бас баяр хүргэх хэрэгтэй.

1 зүйлд жоохон санаа зовж байна. Энэ юу вэ гэхээр Зөрчлийн болон бусад хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах хуулийг 2026 оны намрын чуулганд өргөн барина гэсэн байгаа. Тэгэхээр энэ болохоор хэтэрхий оройтож байна энэ хуулийн хувьд. Яагаад гэхээр энэ хууль ингээд хэрэгжээд эхлэхээр яг Зөрчлийн хуультай холбоотой янз бүрийн зөрчлүүд гарна. Тэгэхээр энэ асуудал дээр зөрчлүүд гарахаар яаж шийдэх юм бэ. Хууль нь байхгүй. Тэгэхээр энэ хуультайгаа дагаж уг нь оруулж ирэх байсан. Яг энэ хуультай холбогдуулаад Зөрчлийн хуулиа яаралтай горимоор оруулаад ирвэл бас Улсын Их Хурал батлах боломжтой.

3 асуулт байна. 1 дүгээрт энэ тогтоолын 2 дугаар заалтад “эрүүл мэндийн” гэсний ард “шашны байгууллага” гэж бас нэмэх саналтай байна. Энийг та бүхэн бас тогтоолын төсөлд бодолцоорой. Яагаад гэхээр энэ амьгүй донорын асуудал дээр шашны байгууллагуудын оролцоо маш чухал байдаг юм.

2 дахь нь бол энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулна гэсэн байгаа. Үүний дараагаар Засгийн газрын тусгай сангийн хуульд бас өөрчлөлт оруулна гэхэж. Тэгэхээр энэ 2 нь ямар холбоотой юм бэ. Хоёулангаас нь энэ асуудалд хөрөнгө гаргана гэсэн үг юм уу гэдгийг тодруулж өгөөч.

3 дугаарт энэ барилгын ажил хэдийд дуусаад ашиглалтад орох вэ. Байгууллагаа үүнтэй уялдуулж бас байгуулах хэрэгтэй гэж хэлэх гэсэн юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Хэн хариулах вэ. 4 дүгээр микрофон дээр Алтантулга хариулъя.

Б.Алтантулга: Мэндийн хөгжлийн төвийн Эрхтэн шилжүүлэн суулгах албаны дарга Алтантулга. Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Эхнийх дээр бол бид нар алба байгуулагдсанаас хойш энэ шашны төлөөллүүдтэй байнгын холбоотой ажиллаж байсан. Тэр дундаа бол Монголчуудын дийлэнх нь Буддын шашинтай. Тэгээд тэр дундаа бид нар Гандан болон шашны төлөөллүүдтэй яг биечлэн уулзаад, эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах, амьгүй донор тэр дундаа хүнд амьдрал бэлэглэх гэдэг бол хамгийн том буян гэж номлодог юм

байна лээ гэж бид нартай зөвлөлдөж ярилцсан. Цаашдаа бид нар энэ шашны сургууль, тэр дундаа шашны төлөөллүүдтэй бол байнгын хамтарч ажиллана.

2 дахь асуудлын тухайд бол Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай. Энэ маань одоо бол амьгүй донор болсон гэр бүлд оршуулгын тэтгэмж өгөх асуудал нь 2 сангаас олгож байгаа асуудлыг ажлын хэсэг ярилцаад, 1 сангаас олгох нь зүйтэй юм гээд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дээр яг тодорхой, ямар нэгэн салаа утгагүй байдлаар илүү тодорхой оруулж өгч байгаа. Одоо бол даатгал төлөгч болон төлөгч биш эсэхээс үл хамаараад амьгүй донор болсон тохиолдолд түүний гэр бүлд оршуулгын тэтгэмжийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу дэмжих сангаас нь олгогдоно гэж ингэж оруулсан байгаа.

3 дахь асуудлын тухайд 1 дүгээр эмнэлгийн дэргэд барьж байгаа Эд, эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төвийн асуудал бол яг 1 дүгээр эмнэлгийн төвийн өргөтгөл баригдаж байгаа. Барилгын явц маш сайн явж байгаа. Энэ бол 2028 онд орно гэсэн ийм төлөвлөлттэй ажиллаж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Одоо удахгүй санал хураалт явна шүү гишүүд ээ. Танхимдаа хүрэлцэн ирье.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэвэгдоржийн Туваан, Жигжидийн Батжаргал нарын урилгаар Төв аймгийн Батсүмбэр сумын ЕБС-ийн 12^А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй сургуулиа төгсөөд, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг боловсрол эзэмшин, эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулсан хариуцлагатай, хуулиа дээдэлдэг иргэн болоорой. Монгол Улсын маань бас ирээдүй та бүхний гарт байгаа шүү гэдгийг бас та бүхэндээ дахин хэлье. Тэгээд аав ээжийнхээ үгэнд, багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Амгаланбаатар гишүүн суудал хуралдаа сууна уу. Танхимд өнөөдөр 126 гишүүнээс 92 гишүүн ирцдээ орсон байна. Санал хураалтад 56 гишүүн бэлэн болсон байна. Бэлэн бус байгаа 36 гишүүнийг санал хураалтдаа бэлтгэхийг хүсэж байна. Гишүүд суудалдаа суугаад, ирцдээ орж, санал хураалтдаа хурууны хээг уншуулж бэлэн болъё. Бүртгэлийн ирцийн санал хураалт явуулъя. 92 гишүүнээс 60 гишүүн танхимд сууж байна. 32 гишүүнийг танхимдаа орж ирэхийг хүсье.

Байнгын хорооноос “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гарсныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 70,7 хувийн саналаар дэмжигдлээ.

Батсүмбэрэл гишүүн, Наранбаяр гишүүн, Цогтбаатар гишүүдийг дэмжсэнд тооцъё. 68 гишүүн дэмжлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалтыг Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн баталсны дараа явуулахаар хуулийн төслийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Энэ бас заримдаа эрхтэн, эд, эс гэж яваад, заримдаа эс, эд, эрхтэн гэж яваад байгаа шүү. Нэр томъёоны хувьд бас энийгээ зөв болгоорой. Сая ажлын хэсгийг танилцуулахад эс, эд эрхтэн гэж танилцуулж байсан.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

10.24 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг танилцуулна. Индэрт урьж байна. Санал хураалттай гишүүд чуулганахаа танхимд сууж байгаад, санал хураалтаа өнөөдөр явуулчихъя. Тухай бүрд нь явуулчихъя.

М.Ганхүлэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсгийг баримтлан Байнгын хорооноос боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24 дэх хэсэгт заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төсөл баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ганхүлэг гишүүнд баярлалаа. Ажлын хэсэг түрүүний ажлын хэсэг хэвээрээ. Цаашдаа энэ хууль батлагдаад гарахаар тэр ажлынхаа байгууллагынхаа нэрийг бас өөрчлөөрэй. Эс, эд, эрхтэн биш эрхтэн, эд, эс.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл орж ирлээ. Энэ тусгай сангийн зарцуулалтыг амьгүй донорын гэр бүлд олгох 1 удаагийн оршуулгын тэтгэмж гэдгийг нэмж өөрчлөн найруулан яг энэ хууль дээр орж ирж байгаа. Ингээд судлаад үзлээ. Тэгэхээр ажлын хэсэг хариулаад өгөөрэй. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль гээд байна. Энэ хуулийн 8.3-д нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Үндэсний зөвлөл батална гээд. 2023 оны 8 сарын 2-нд болохоор Үндэсний зөвлөл 3 сая 500 мянган төгрөгийг амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгоно гээд тэтгэмжийн хэмжээг нь баталчихсан. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа юм байна. Тэгэхээр танай хуулийг дагаж орж ирж байгаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль батлагдах юм бол давхардаад олгогдох юм шиг. Нэг нь нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу, нөгөөдөх нь болохоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу ингэж уншигдаад байх юм. Энэ дээр хариулт өгөөч ажлын хэсгийнхэн. Аль нэгийг нь хүчингүй болгох эсвэл давхардуулж болох юм уу, болохгүй юм уу. Энэ дээр асуулт байна.

Хоёрдугаарх нь болохоороо танай энэ хуулийн төсөл дээрх найруулга нь амьгүй донорын гэр бүлд олгох 1 удаагийн оршуулгын тэтгэмж, тэрний найруулга нь өөр юм шиг. 1 удаагийн оршуулга гэж, 2 удаагийн оршуулга гэж бол баймааргүй юм. Тэгээд бас гэр бүлд нь гэх юм гэр бүлгүй хүмүүс бас байгаа шүү дээ. Тэгэхээр энэ асуудлыг яаж шийдэх юм. Энэ найруулга дээр нь хэн анхаарах ёстой вэ. Ийм 2 үндсэн асуултад хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Ариунзаяа гишүүн хариулья.

А.Ариунзаяа: Нийгмийн даатгалын хуулиар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, нийгмийн даатгалын харилцаанд орсон хүн бүр оршуулгын тэтгэмж авдаг. Энэ бол донор болсон эсэхээс үл хамаарч угаасаа олгогддог асуудал. Өнгөрсөн 2022 онд нийгмийн даатгалын үндэсний зөвлөл ямар шийдвэр гаргасан бэ гэхээр яг энэ амьгүй донорын ар гэрт нь амьгүй донор болсонд нь илүү хүндэтгэл үзүүлэх ийм шийдвэрийг оршуулгын тэтгэмжийг ердийн оршуулгын тэтгэмжээсээ нэмэгдүүлж олгоё гэдэг ийм шийдвэрийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл гаргасан. Яагаад энэ шийдвэрийг гаргах болсон юм бэ гэхээр тухайн үедээ Донорын тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулахад яг энэ бусад улс оронд олгогддог энэ талархлын тэтгэмжийг оруулсан байсныг Улсын Их Хурал тухайн үедээ ач холбогдлыг нь ойлгоогүй унагааснаас үүдэж ядаж нийгмийн даатгал өөрийнхөө энэ оршуулгын тэтгэмж дээрээ энэ талархлын тэтгэмжийг оруулъя гэсэн ийм шийдвэрийг би сайдаар ажиллаж байхад оруулсан юм.

Түүний дараагаар ямар асуудал үүссэн бэ гэхээр нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, нийгмийн даатгалын харилцаанд ороогүй хүмүүс яах юм бэ гэдэг орхигдсон асуудал үүссэн учраас тухайн үедээ Эрүүл мэндийн сайд Эрүүл мэндийн сангаас олгох ийм өөрчлөлтийг Засгийн газрын тусгай сангийн энэ хуульдаа бас өөрчлөлт оруулаад ингээд нийгмийн даатгалын төлөлтийн харилцаанд орсон хүнд бол нийгмийн даатгалын сангаас, ороогүй хүнд бол Эрүүл мэндийг дэмжих сангаас одоогийн байдлаар олгогдож байгаа. Хууль одоогоор юу гэж өөрчлөгдөж байгаа вэ гэхээр Эрүүл мэндийг дэмжих сангаас энэ яг амьгүй донорын ар гэрт нь олгодог байя буюу гэр бүлд нь олгодог байя гэдэг ийм өөрчлөлт орж байгаа. Энэ нь бол яг амьгүй донорт нийгмийн даатгалын сангаас олгогдох энэ оршуулгын тэтгэмж нэмэгдэж олгогдоно гэсэн үг огтоос биш. Тэгэхээр бидний дөнгөж сая түрүүхэн баталсан хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоол дээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тухайн тогтоолыг өөрчлөх ийм даалгавар өгсөн байгаа. Тэгэхээр одоо бол амьгүй донорын гэр бүлд нь зөвхөн Эрүүл мэндийг дэмжих сангаас энэхүү тэтгэмжийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн дүнгээр олгоно гэсэн ийм зүйл заалт, зохицуулалт орж байгаа. Тэгэхээр давхардуулан олгоно гэсэн ойлголт байхгүй. Гэхдээ амьгүй донорт нийгмийн даатгалын сангаас олгогддог ердийн оршуулгын тэтгэмж олгогдохгүй гэсэн үг бол биш. Тэгэхээр яг энэ амьгүй донорын тэтгэмж нь тэтгэмж гэдэг юм уу, талархал нь өөрөө оршуулгын тэтгэмж гэдэг 1 удаагийн оршуулгын тэтгэмж гэдэг ийм нэршилтэйгээр одоогийн байгаа зохицуулалт дээр нэмэлт, өөрчлөлт маягаар орж байгаа. Тэгэхээр шинээр Засгийн газрын сангийн хуулийг өөрчилж, шинэ заалт оруулж байгаа юм биш. Энийг зүгээр өөрчлөн .../минут дуусав/

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар нийслэлийн нийслэлийн ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн 12^А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа эрхэм сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Удахгүй сургуулиа төгсөөд, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг боловсрол эзэмшин, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан хариуцлагатай, хуулиа дээдэлдэг иргэн болоорой. Тэгээд Монгол Улсын ирээдүй та бүхний гарт байгаа шүү. Аав ээж, багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай.

Болдын Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Гэр бүлийн тухай хуулийг харъя. 3.1.2 дээр гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг гэж тодорхойлсон байгаа. Тэгэхээр энэ 19.3.6 дээр Тусгай сангийн тухай хууль дээр та хэдийн оруулж өгч байгаа үг нь амьгүй донорын гэр бүлд олгох 1 удаагийн гэж байгаа. Тэгээд гэр

бүлгүй, яг энэ гэр бүл гэсэн тодорхойлолтод хангагдахгүй хүнийхээ эрх ашгийг бүгдээрээ яаж хангах вэ. Тэгэхээр ер нь бол донорт алдаршуулна, талархана гэдгийг ерөөсөө эсэргүүцээд байгаа юм бол байхгүй шүү дээ. Зүгээр зөв оруулж өгөхгүй бол яг энэ хуулийг ингээд судлаад, ухаад үзэхээр нийгмийн даатгал шимтгэл даатгалын санд хамааралтай бол нийгмийн даатгалынхаа тэр тусгай сангийнхаа тухай хуулиар тэтгэмж 3 сая 500 мянган төгрөг авчих юм байна. Тэгээд 2023 оны 8 дугаар сарын 2-нд батлагдсанаар хар л даа. Тэгээд давхардах гээд л байгаа юм шиг байх юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Дахиад маш тодорхой хэлье. Давхардуулан амьгүй донорын гэр бүлд оршуулгын тэтгэмж давхардуулан олгогдохгүй. Тухайн хүн амьгүй буюу тархины үхжилттэй байлаа гэхэд угаасаа манай эд, эс, эрхтний хамтарсан баг гэр бүлээс нь зөвшөөрөл авдаг. Гэр бүлгүй хүнээс хэнээс зөвшөөрөл авах вэ дээ, амьгүй донор болох боломжгүй шүү дээ.

Тийм учраас угаасаа процесс байгаа. Угаасаа гэр бүлтэй байгаа. Тэгэхээр бусад хуулиудаар яг адилхан гэр бүлд нь гэж тодорхойлсон байгаа учраас гэр бүлд нь олгоно. Давхардуулан олгогдохгүй. Амьгүй донор болсон гээд Эрүүл мэндийг дэмжих сангаас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн дүнгээр оршуулгын тэтгэмж авч байгаа нь тухайн хүн өөрөө нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн харилцаанд ороод, ердийн оршуулгын тэтгэмжийг нийгмийн даатгалын сангаас авах эрх нь бол хаагдахгүй. Авдгаараа л авна. Энэ бол тусдаа харилцаанууд үүсэж байна гэсэн үг.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон нэмж хариулт өгье.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Уянга гишүүний асуултад нэмж хариулъя. Мөн Ариунзаяа гишүүний бүрэн хариулттай санал 1 байна. Манай албаны зүгээс 2018 онд байгуулагдаад өнөөдрийг хүртэл бид нар амьгүй донорын гэр бүлтэй уулзаж, яг донор болох хүсэлт тавьж, зөвшөөрөл авдаг. Энэ тохиолдолдоо бид нар амьгүй донорын яг хамгийн ойр дотнын гэр бүлийн гишүүдтэй уулзаж, холбогдох 3 хүртэлх гэр бүлийн гишүүнээс Эрүүл мэндийн сайдын батлагдсан маягтад амьгүй донорын зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулаад, ингэсэн тохиолдолд яг бид нар донор гэж үзээд эрхтэн авах мэс заслаа зохион байгуулдаг. Яг энэ асуудлын хувьд гэх юм бол амьгүй донорын гэр бүлд угаасаа олон улсын жишигт ч гэсэн амьгүй донорын гэр бүлд тэтгэмж нь бол олгогддог байгаа. Тэгээд энэ ч үүднээсээ амьгүй донорт мэдээж гэр бүлээс нь зөвшөөрөл авсан юм чинь мэдээж эргүүлээд гэр бүлийн гишүүнд оршуулгын тэтгэмжийг нь өгөх асуудал нь энэ хуулиараа зохицуулагдана. Үүгээрээ бид нар яг 2 сангаа илүү ойлгомжтой болгох үүднээсээ 1 сан дээрээ төвлөрүүлье. Энэ сангаасаа л яг оршуулгын тэтгэмжээ даатгал төлөгч байна уу, үгүй байна уу гэдгээс нь үл .../минут дуусав/

С.Бямбацогт: Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Тусгай сангийн хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй байх. Энэ давхардуулан гэхээс гадна түрүүн асуугаад байсан давхардахгүй гэсэн. Давхардуулан гэхээсээ гадна нөгөө орхигдох тийм гэр бүл гарах уу, үгүй юу. Энэ

зайгаа хоосон хий зай үлдсэн үү, үгүй юу гэдгийг бас асууж байна. Амьгүй донорын ар гэр дэмжлэгээ авахгүй үлдэх тийм зай үлдээхгүйгээр хийсэн үү.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Ариунзаяа гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Амьгүй донор болох энэ зөвшөөрөл олгох амьгүй донороор тухайн ямар эд, эсийг өгөхийг зөвшөөрч байгаа вэ гэхчлэн маш олон процессууд өмнө нь явж байгаа учраас энэ олон процесс, үйл явдлын дотор оршуулгын тэтгэмж гэдэг юм уу, яг амьгүй донор болсных нь төлөө олгож байгаа энэ талархлын бусад улс оронд байдаг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгогдох энэ 1 удаагийн тэтгэмж нь олгогдохгүй орхигдоно гэсэн асуудал бол байхгүй. Энэ болбол өөрөө үйл явц, процессын 1 хэсэг байгаа учраас орхигдоно гэсэн асуудал бол байхгүй. Яагаад гэвэл энэ чинь зөвшөөрөл өгөхөөс авхуулаад маш олон оролцоо, харилцаа үүсэж байгаа учраас дараад нь хэнд энэ мөнгийг нь өгөх вэ гэдэг ч юм уу, гэр бүлгүй байх юм биш үү гэдэг ч юм уу ийм орхигдох боломж гарахгүй гэсэн үг. Яг зөвхөн оршуулгын гэдэг юм уу, амьгүй донорын 1 удаагийн тэтгэмжийн асуудлыг ярьж байгаа бол энд орхигдоно гэсэн асуудал байхгүй.

Нийгмийн даатгалын сангаас олгогдож байгаа ердийн оршуулгын тэтгэмж бол өөрөө тусдаа асуудал учраас үүнийг энэ асуудал дээр бол хольж ярих нь буруу байх гэж үзэж байна.

С.Бямбацогт: Батбаатар гишүүн тодруулж асууя.

Б.Батбаатар: Зүгээр энэ асуултыг яагаад асууж байна гэхээр ажил үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн төрийн албан хаагчид нөхөн олговор өгдөг. Тэгээд 1 байгаль хамгаалагч 50 хэдэн сая төгрөгийн нөхөн олговор авах ёстой байж байгаад нөгөө 5 сарын 31 болоод буцаан татагдаад, дараа нь төсөвт суулгах гээд суулгаж чадахгүй 2 жил болчихсон. Ар гэрийнхэн нь ингээд байгаль хамгаалж яваад түймрийн нөхцөл байдлын улмаас амь насаа алдчихсан. Тэгээд тэрийг нь төсөвт суулгаж өгөхгүй болохоор нөгөө ар гэр нь тэр тэтгэлгийг хуулийн дагуу авч чадахгүй ингээд яваад байдаг. Түүнтэй адилхан төсвийн асуудал юм уу, бусад асуудлаар ингээд ар талыг нь хохиролтой үлдээчих асуудлыг үлдээхгүй байх тал дээр гүйцээж нягталсан уу гэдгийг бодит жишээн дээрээс үндэслээд бас давхар асуусан юм.

С.Бямбацогт: Ариунзаяа ажлын хэсгийн гишүүн хариулъя.

А.Ариунзаяа: Батбаатар гишүүний санаа зовниж байгаа асуудал зөв. Ер нь бол төр өөрөө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой байхгүй юу. Тэрнээс чинь төсөв нь татагдсан гээд тухайн хүмүүсийг хохироож болохгүй шүү дээ. Ийм учраас төр үүргээ биелүүлээгүй гээд тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийг шүүхэд өгөх хэрэгтэй. Үнэхээрийн өгөөгүй байгаа бол. Тэгээд энэ дээр бол захиргааны хэргээр шийдүүлээд, төр буюу тухайн төсвийн ерөнхийлөн захирагч өөрөө бас энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас энэ хариуцлагаа хүлээх ёстой. Ийм учраас яг энэ амьгүй донорын урамшууллын тухайд бол угаасаа жилд маш цөөхөн хүмүүс гардаг. Тэгээд энэ тодорхой хэмжээнд бид нар талархал дэвшүүлэх ёстой гэдэг үүднээсээ Эрүүл мэндийг дэмжих сангаас олгох ийм зохицуулалтыг хуулиар бол юу гэдэг юм зохицуулж байгаа. Тэгэхээр энэ агуулгаараа төр энэ үүргээ хүлээнэ гэдэг амлалт өгч байна л гэж ойлгох хэрэгтэй.

С.Бямбацогт: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр эрхтэн, эд, эс шилжүүлэх энэ үйл явц бол нэлээн олон жилийн хугацаанд хийгдсэн. Бас саяхан одоо манай өрөөнд манай хамаатны хүн ирээд яг энэ эрхтэн шилжүүлэх энэ мэс заслын хүрээнд бас олон жил амьд явах сайхан боломж олдлоо гээд. Тэгээд энэ нь хуулийг бас тодорхой хэмжээгээр дэмжиж өгөөрэй гэдэг ийм л зүйлийг ярьж байсан. Тэгэхээр ер нь бол мэдээж дэлхий нийтийн эрүүл мэндийн шинжлэх ухаанд тодорхой хэмжээний амжилт гаргасан ийм зүйлийг Монголдоо нутагшуулах энэ ажлыг мэдээж олон олон эмч нар бүгдээрээ хийж байсан.

Тэгээд би Батчулуун доктороос бас тодорхой зүйл асууя гэж бодож байна л даа. Тэгэхээр энэ амьгүй донорыг илүү ар гэрийнхний зөвшөөрөлтэйгөөр илүү тэр эрхтэн, эд, эсийг нь шилжүүлж, энэ өвчнөөр шаналж явж байгаа тэр хүмүүсээ аврах нь бол манай Монголын төрийн болон эрүүл мэндийн шинжлэх ухааны гол ажлуудын 1 л дээ. Тэгэхээр энэ дээр цаашдаа энэ хууль батлагдсанаар урьд нь хийж байсан тэр эрхтэн, эд шилжүүлэх тэр мэс заслын тоо хэмжээ илүү нэмэгдэх үү.

2 дугаарт нь энэ хууль дээр бас тодорхой хэмжээний төв байна гээд заачихсан байгаа. Тэгэхээр Анагаахын шинжлэх ухааны хашаан дотор байгаа тэр төв чинь яг танай төв болох юм уу. Цаашдаа энэ төв нь яаж санхүүжүүлэгдэх юм. Хамгийн гол нь Эрүүл мэндийн яам болон төсвөөс санхүүжигдэж явах уу. Аль эсвэл тодорхой хэмжээний эрхтэн, эд, эс шилжүүлэх мэс заслын үйл ажиллагаанаас санхүүжигдэх үү. Энэ дээр бас тодорхой мэдээллийг та бүхэн хийж өгөөч ээ гэж хүсэж байна.

Ер нь бол энэ ач холбогдлыг нь бас сайн яг энэ хуулийн хүрээнд бас ярьж өгөх нь зүйтэй байна.

С.Бямбацогт: Энэ их чухал хууль баталж байгаа. Үнэхээр ард иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюул цаг минутаар уралдаж байгаа үед ач холбогдлыг нь сайн тайлбарлаж ойлгуулж өгөх нь зөв. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

П.Батчулуун: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн хөгжлийн төв Батчулуун байна. Дэлхийн эрүүл мэндийн практикт бол 1963 оноос эхлээд энэ амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг бол эхлүүлсэн байгаа. Манай улс бол амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээг сүүлийн 2018 оноос эрчимтэй хөгжүүлж яваа. Тэгээд амьгүй донорын гэр бүлд оршуулгын зардал өгсөнтэй холбоотой энэ хуульд заасны дагуу тодорхой хэмжээний оршуулгын зардал өгснөөр нөгөө энэ эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ бол нэмэгдэнэ гэж үзэж байгаа. Учир нь бол бид нар энийг судалж үзсэн. БНСУ, БНТУ гээд бид нартай хамгийн ойр дотно ажилладаг энэ улсууд маань бол амьгүй донорынхоо үйл ажиллагааг идэвхжүүлэх, ард олондоо бас тусламж дэмжлэг үзүүлэхийн тулд гэр бүлд оршуулгын зардал өгдөг асуудлуудыг дэвшүүлээд, энэ нь хүлээн зөвшөөрөгдөөд өнөөдөр эрүүл мэндийн практикт хэрэгжсэн байгаа учраас бид нар бас энийг авч хэрэгжүүлье гэсэн асуудлыг энэ хуульдаа оруулсан юм.

Дараагийн асуулт энэ улсын 1 дүгээр төв эмнэлгийн хашаан дотор баригдаж байгаа эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах төв бол 2019 онд Эрхтэн шилжүүлэн

суулгах төв баригдах асуудлуудыг тавьж ярьж эхэлснээс хойш Улсын 1 дүгээр төв эмнэлгийн хашаан дотор бол Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах эмчилгээ үйлчилгээ явуулах энэ төв нь бол баригдаж байгаа юм. Энэ ажил бол тухайн үед Монгол Улсын Ерөнхийлөгч байсан Халтмаагийн Баттулга Ерөнхийлөгчийн дэмжлэгтэйгээр эхэлж байсан ийм ажил. Өнөөдөр ингээд ажил хэрэг болоод явж байгаад маш их баяртай байгаа.

Дараа нь манай Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах төрийн байгууллага нь бол мэргэжлийн төв байх гэдэг асуудал байгаа. Тэгэхээр энэ нь бол бодлогоо баримтлах юм. Энэ бодлогоо баримтлаад, хэрэгжүүлэлтдээ хяналт тавиад, үйл ажиллагаагаа дүгнээд, үр дүнг нь Монгол Улсын Эрүүл мэндийн яам, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, цаашлаад ДЭМБ-д өгдөг энэ бодлогын байгууллага байх юм. Энэ хоёрын төсөв болон санхүүжилт нь бол мэдээж мэдээж улсын төсвөөс бол хангагдах байх гэж бодож байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Зочин танилцуулъя.

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын иргэд, малчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Манай баруун бүсээс 10 гишүүнийг та бүхэн сонгосон байгаа. Тэгээд бүгд бас Улсын Их Хурлынхаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог гишүүд байгаа шүү. Одоо Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж, Амарбаясгалан, ингээд өөр хэн сууж байна. Болормаа гишүүн байна. Тэгээд та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Ганхүлэг гишүүн чинь өөрөө ажлын хэсэг биз дээ. Танилцуулга уншчихаад өөрөө өөрөөсөө асуугаад хариулна гэх дэг байхгүй л дээ. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя. Алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүдийг танхимдаа орж ирэхийг урьж байна. Санал хураалттай. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Танхимд нэлээн гишүүд шингэрсэн харагдаж байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууж байя. Өрөөндөө сууж байгаа гишүүдийг бас танхимдаа хүрэлцэн ирэхийг урья. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Хүний амь настай холбогдолтой чухал хуулийн төсөл бас санаачилсан, ажлын хэсэгт ажилласан ажлын хэсгийн гишүүддээ бас дахин дахин талархал илэрхийлье. Нарийвчилсан бас зохицуулалтууд хийх зайлшгүй шаардлагатай байсан Эрхтэн, эд эс шилжүүлэн суулгах тухай энэхүү хуулийн төслийг бас баталсан нь одоо чухал гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгээ бас илэрхийлье.

Энэ орж ирж байгаа тусгай сангийн хуультай холбогдолтой яах вэ, ер нь өмнөх хугацаанд хэчнээн хэмжээний донорууд бас байсан бэ. Хэдий хэмжээний мөнгө зарцуулах тухай бид бүхэн ярьж байгаа вэ гэдгийг бас мэдээлэл өгөх нь зөв байх гэж бодож байна. Энэ зохицуулалтын гол зорилго нь бол донорын тоог нэмэгдүүлэх ийм үндсэн зорилготой. Тэгэхээр яг одоо амьгүй донорт олгож байгаа бараг ганц бодитой дэмжлэг нь бол энэ дэмжлэг л үндсэндээ болж байгаа. Тэгэхээр энэ хууль

батлагдаж, тодорхой мөнгөн урамшууллыг, тэтгэмжийг нэмэгдүүлснээрээ бас тодорхой үр дүнгүүд гарна гэсэн ийм хүлээлттэй байна. Тэгэхээр энэ дээр тодорхой тоо мэдээллүүдийг авъя.

Бусад улстай харьцуулахад би бас төдийлөн өндөр гэж бас бодохгүй байна. Олон улсад бас донорууддаа тодорхой хэмжээний тэтгэмж олгож байгаа энэ зүйлүүдтэй харьцуулсан харьцуулалтыг бас олон нийтэд мэдээлэл өгөх нь зөв байх гэж бодож байна. Тэгээд давхардуулахтай холбогдолтой болон тэр бусад энэ төрлийн дэмжлэгүүдийг цаашдаа илүү нэмэгдүүлэх чиглэлээр бас гол ажлуудаа анхааруулаасай гэдэг үүднээс ганц нэгэн саналуудыг бас хэлье гэж бодож байна.

Үндсэндээ бусад зарим улс орнуудад бол оршуулгын зардал өгөхөөс гадна тухайн гэр бүлд нь, ялангуяа Израил, хэд хэдэн улсуудад бол тухайн гэр бүлд нь дараалалд бас давуу эрхтэй олгох орох ийм бас боломжийг олгодог ийм туршлагауд бас байдаг юм байна. Нийгмийн халамж болон бусад тусламжуудыг өгдөг ч бас улсууд байна. Хамгийн чухал анзаарсан зүйл нь бол гэр бүлд нь зориулсан тусгай ийм сэтгэл зүйн зөвлөгөө, нарийн мэдээллүүдийг өгдөг ийм бас туршлагауд байна. Тэгэхээр хуулийн төсөлд туссан, тусаагүй тодорхой эдгээр туршлагаудыг нэвтрүүлэх чиглэл дээр цаашдаа гол анхаарал хандуулж бас ажиллах нь зөв юм гэдгийг бас протоколд тэмдэглүүлж, санал болгож илэрхийлье.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулчихъя. Бас тодорхой асуулт асуулаа. Тоонууд асуусан. Гишүүд санал хураалтдаа, танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Чуулганы танхимд хүрэлцэн ирнэ үү. Үүний дараа санал хураалттай.

Б.Алтантулга: Эрүүл мэндийн хөгжлийн төв Алтантулга. Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Манай алба 2018 онд байгуулагдсанаас хойш бид нар өнөөдрийн байдлаар 75 гэр бүлд амьдрал бэлэглэсэн гэсэн үг. Тэгэхээр яг алба байгуулагдсанаас хойш бол амьгүй донорын энэ үйл ажиллагаа бол харьцангуй нэмэгдсэн. Энэ хуулийн төсөл батлагдсантай холбоотой мөн амьгүй донорын илрүүлэг болон эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ маань бол хэд дахин нэмэгдэнэ гэж бид үзэж байгаа. Энэ дундаа бол оршуулгын тэтгэмж өгөх асуудал анх бол 2022 онд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол батлагдаад, 2023 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн байгаа. Энэ хүрээндээ нийгмийн даатгалын халамжийн сангаас 2023 онд 1 хүн, 2024 онд 4 хүн, 2026 онд 1 хүн гээд нийт бол 22 сая төгрөгийн оршуулгын тэтгэмжийг олгосон байна. Даатгал төлөгч биш тохиолдолд Эрүүл мэндийн дэмжих сангаас 2023 онд 1 хүнд оршуулгын тэтгэмжийг өгөх асуудал бол шийдэгдсэн байна. Тэгэхээр бид нар энэ оршуулгын тэтгэмжээ жилд хамгийн багадаа 10 амьгүй донор гарч гарч болно гэж тооцоолоод, дэмжих сангаас болоод хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн дүн гэхээр жилд ойролцоогоор 70 орчим сая төгрөгийн зардал гарах нь гэж бид тооцоолсон байгаа.

Бусад улстай харьцуулахад гэх юм бол жишээ нь БНСУ-д оршуулгын тэтгэмжийг амьгүй донор болсон тохиолдолд бүрэн зардлыг нь энэ дааж байгаа тогтолцоо байдаг. Ямар ч л байсан бид нар энэ хуулийн төсөлдөө оршуулгын тэтгэмжийн тодорхой хэмжээний зардлыг зохицуулъя гэж үзэж байгаа. Монгол улсад дунджаар оршуулгын зардал бол хамгийн багадаа 6 саяас эхэлдэг. Хамгийн дээшээ бол мөнгөн дүн хязгааргүй. Тэгэхээр бид нар 6 саяас 10 саяын хооронд байдаг гэж тооцоолсон байгаа. Тэгэхээрээ оршуулгын тэтгэмжийг хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээ гэдэг бол бид нар хангалттай гэж үзэж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Гишүүд санал хураалтдаа бэлдэцгээгээрэй. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн зочин. Танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Жаргалсайханы Золжаргалын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын Монгени сургуулийн 12^е ангийн багш сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. Удахгүй сургуулиа төгсөөд, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг, боловсрол эзэмшин, эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулсан хариуцлагатай, хуулиа дээдэлдэг иргэн болж төлөвшөөрэй. Аав ээжийнхээ, багш нарынхаа үгэнд сайн орж байгаарай хүүхдүүд ээ.

Санал хураалтдаа бэлтгэе гишүүд. 98 гишүүн ирцэд орсноос одоогоор бүртгэлд 55 гишүүн ороогүй байна шүү. Санал хураалтад 43 гишүүн бэлэн болсон байна. Өрөөндөө ажлаа хийж байгаа гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирж санал хураалтад оролцохыг урьж байна. Бүлгийн дарга нар, бүлгийн дэд дарга нар, бүлгийн ажлын алба, Хуралдаан зохион байгуулах газар гишүүдийг танхимд хүрэлцэн ирэх арга хэмжээ авъя. Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ чуулганы танхим руу явуулаарай. 53 гишүүн танхимд сууж байна шүү. 2 гишүүн хуруугаа уншуулаагүй юм шиг байна. Гишүүд өөр өөрсдийнхөө төхөөрөмжийг үзэж шалгачхаарай. Санал хураалтдаа гишүүд бэлдсэн. Бүртгэлийн санал хураалтыг явуулчихъя. Бүртгэл. Батсуурь гишүүн суудлаа эзэлье. Санал хураалтаа явуулна.

Байнгын хорооноос гаргасан, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 98 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 52 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

11.00 цаг.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар Сүхбаатар дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдийн сувилагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сувилагчдаа төлөөлж Төрийн ордонд зочилсон та бүхэндээ удахгүй болох сувилагчдын баярын мэндийг нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс өргөн дэвшүүлъя.

Дараагийн асуудалдаа оръё.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан танилцуулна. Энэ нэлээн олон санал хураалттай байгаа гишүүд ээ.

Ж.Баясгалан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Ж.Алдаржавхлан, А.Ариунзаяа, Н.Батсүмбэрэл нараас 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцүүлэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаараа Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын даргын 2025 оны 253 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

1.Цусны донорын тухай хууль тогтоомжийн нэр томъёоны тодорхойлолтуудыг үг хэллэгийг иргэд, олон нийт, эрүүл мэндийн ажилтнуудад ойлгогдоход хялбар, энгийн, хоёрдмол утгагүй байдлаар илүү нарийвчлан томъёолж, хуульд хэрэглэгдэж буй цусны донорын сэрэмжийн тогтолцоо, байнгын донор зэрэг зарим нэр томъёоны тайлбарыг тодорхойлолтод нэмж тусгалаа.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн харьяалалгүй хүний эрүүл мэнд, амийг аврах зорилгоор цус сэлбэх тусламж үйлчилгээг үзүүлэх зохицуулалтыг нэмж тусгалаа.

3.Монгол Улсад төдийгүй дэлхий нийтэд уур амьсгалын өөрчлөлт хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгаль, цаг уур, биологийн гаралт, аюулт үзэгдэл, гамшиг ослын тоо, давтамж, түүнээс учрах хохирол жил бүр өсөн нэмэгдэж байгаа энэ үед хүний эрүүл мэнд, амийг аврахад нэн шаардлагатай цус, цусан бүтээгдэхүүний нөөцийн бэлэн байдлыг хангах нь гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэхэд чухал асуудал юм. Түүнчлэн цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг сайжруулах хүрээнд нарийн мэргэжлийн ур чадвар, тасралтгүй сургалт, хөгжлийг шаарддаг эрсдэлтэй, өндөр хариуцлагатай нөхцөлд ажилладаг цус сэлбэлт судлалын ажилтнуудад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох зэрэг заалтыг нэмж тусгалаа.

4.Цусны донорт тавигдах шаардлага, эрх, үүргийн асуудлыг олон улсын жишиг зарчимд нийцүүлэн томъёолсон.

5.Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын болон Дэлхийн эрүүл мэндийн Ассамблейн 210 дугаар тогтоолын дагуу сайн дурын, төлбөргүй зарчмыг хуулийн төсөлд мөрдлөг болгож тусгасан.

6.Цус сэлбэлт судлалын салбарын үйл ажиллагааны зохицуулалтын удирдлагын тогтолцоо, үйл ажиллагааг илүү оновчтой болгох хүрээнд цусны донорын үйл ажиллагаанд оролцож байгаа төрийн болон төрийн бус байгууллага, эрүүл мэндийн байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үүргийг нарийвчлан тодорхойллоо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үеэр Улсын Их Хурлын гишүүн Ганхүлэг Цусны донорын тухай хуулийн төслийн 2.1-д заасан Монгол Улсын олон улсын гэрээ гэснийг яагаад хасаж байгаа болон олон улсын гэрээний хүрээнд гадаад, дотоод иргэдийн цус өгөх, авах харилцаа хэрхэн зохицуулагдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан Цусны донорын тухай хууль тогтоомж гэсэн хэсэгт Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг хэрхэн тусгасан талаар, донорын эмзэг мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах, устгах зөвшөөрөл авах болон хариуцлагын зохицуулалт хэрхэн хийгдэж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Бум-Очир Цусны донорын хомсдол хэрхэн үүссэн талаар, хүмүүс яагаад байнгын донор болдоггүй, шинэ хууль энэ хомсдол бууруулахад ямар нөлөө үзүүлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Наранбаяр Цус сэлбэлтийн талаар ажилтнуудад онцгой нөхцөлийн хэрэгцээ, хувь хэмжээ, төсөв, тэтгэвэрт нөлөөлөх эсэх мөн цусны донорын тоо өсөж, буурч байгаа байдал, насны бүтэц болон цаашдын хэрэгцээ, статистик тооцооны талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун Цусны донорын тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хууль зохицуулагдаж байгаа эсэх, хуулийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага, төрийн бус байгууллагын оролцоо хуульд хэрхэн туссан мөн төрийн бус байгууллагуудын зөвхөн сурталчилгааг хийхээс гадна хяналт шалгалтын чиг үүрэгтэй оролцох боломж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр Донорын урамшууллын тогтолцооны хүрээнд олон улсын жишгийн дагуу хүрэл, мөнгө, алтан донор зэрэг шатлалтай үнэлгээ нэвтрүүлэх боломж байгаа эсэх, Засгийн газрын шагнал олгох асуудал ямар журмаар хэрэгжих мөн цус, цусан бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн талаар асууж, ажлын хэсгээс хариултыг авлаа.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа цусны донорын талаарх мэдлэг ойлголтыг ерөнхий боловсролын сургууль болон их сургуулийн сургалтын хөтөлбөрөөр дамжуулан хүүхэд залуучуудад олгох заалтыг яагаад хассаныг асууж, мөн хүндэт доноруудад нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих эрхийг хэвээр үлдээх, энэ нь нийгэмд донорыг алдаршуулах өндөр ач холбогдолтойг онцоллоо.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.25 дахь хэсэгт заасны дагуу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаахыг дэмжсэн болно.

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Цусны донорын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулсан Улсын Их Хурлын гишүүн Жадамбаагийн Баясгалан Танд баярлалаа. Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэн ордог замаа жоохон өргөн болгоё Тамгын газар.

Одоо ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Намжилын Эрдэнэбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Мэндсайханы Наранпүрэв Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Маамхүүгийн Оюунчимэг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын Төрөлжсөн мэргэжлийн тусламж хариуцсан ахлах шинжээч, Нээчингийн Халиун ЦССҮТ-ийн Үйлдвэрлэлийн тасгийн технологич их эмч, Эрдэнэ-Очирын Тунгалагтуяа ЦССҮТ-ийн Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүдийн нэрсийг өгье. Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Тэгээд ерөнхийдөө энэ цусны донортой холбоотой одоо байгаа нөөц, цустай холбоотой хэлэлцэх асуудал ярьж байгаа учраас яг тиймэрхүү мэдээллийг ер нь бүгдээрээ мэдэж байх зүйтэй гэдэг үүднээс асууя.

Тэгэхээр танай хуулийн төслийг үзээд судлахад 2021 оны байдлаар болохоор нийт цусны донорын 74 хувь нь 40 хүртэл насны иргэд байна гэсэн байна лээ. Тэгээд хамгийн идэвхтэй донор болдог нас нь 24-45. Тэгээд ер нь дунджаар буураад яваад байна гээд. Тэгэхээр шууд цус өгч байгаа, донор болж байгаа иргэдийн маань хамрагдалт нь буураад эхлэхээр мэдээж цусны шууд нөөцтэй холбогдоод явчих байх. Тэгэхээр миний асуумаар байгаа зүйл нь яг одоогийн байдлаар цусны нөөц ямархуу байдалтай байгаа вэ. Тэгээд цус авдаг олон аргууд, байршлууд байдаг уу. Ер нь энэ тогтолцоо тал дээрээ бас нэг тайлбар хэлээд өгөөч. Жишээ нь, Улаанбаатар хотод түгжрэлтэй холбоотой янз бүрийн асуудлуудтай холбоотойгоор яг тухайн олон хүн ажилладаг газрууд дээр нь очоод цусаа цуглуулах ч юм уу, урьдчилж мэдээллийг нь өгөөд, зохион байгуулалтыг нь хийх иймэрхүү төлөвлөгөөнүүд байдаг уу. Ер нь мэдээллээ яаж дамжуулдаг вэ. Энэ хууль батлагдсанаар цусны донор болж байгаа иргэдийн тоо өсөх үү. Энэ дээр ямар

аргуудыг авч хуульдаа тусгасан байгаа вэ гэсэн асуултаар эхэлье. Тэгээд тодруулах зүйлээ тодруулъя.

С.Бямбацогт: Анхны хэлэлцүүлэг хийж байгаа учраас асуултад ажлын хэсэг, Байнгын хорооны дарга, эсвэл ажлын хэсгийн ахлагч, эсвэл ажлын хэсгийн гишүүд хариулна. Шаардлагатай бол ажлын хэсгийн бусад гишүүд хариулна. Тийм болохоор Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, ажлын хэсэг Баясгалан гишүүн ахалсан юм байна. Баясгалан гишүүн эрүүл мэндийн шалтгаантай байгаа. Бусад гишүүдээс хариулах уу. Баярбаатар, Энхнасан, Болормаа, Ганмаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат гишүүдээс. Та ажлын хэсэгт байхгүй. Хууль санаачлагч хариулах боломжгүй.

Энэ ажлын хэсэг ахална, ажлын хэсгийн гишүүн болно гэдэг чинь бас үүрэгтэй шүү дээ. Зүгээр нэрээ оруулах төдий биш. Хууль санаачлагчийн өргөн барьсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгээд, юуг нь яаж өөрчилсөн, ямар нэмэлт оруулсан, яаж зассан, яагаад тэгсэн талаараа тайлбарлаж ярих үүргийг хүлээдэг. Тийм болохоор ажлын хэсгийн ахлагч болон ажлын хэсгийн гишүүд, мөн шаардлагатай бол Байнгын хорооны дарга. Тэгэхээр байнгын хорооны дарга хийх, ажлын хэсгийг ахлах, ажлын хэсэгт орж ажиллах бол тодорхой үүрэгтэй. Тэгээд энэ гишүүдээс хэн хариулах вэ. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга чөлөө авсан. Ажлын хэсгийн ахлагч Баясгалан гишүүн бас сая эмнэлгийн чөлөө авлаа. Бусад ажлын хэсгийн гишүүд хариулъя. Баярбаатар, Энхнасан, Болормаа, Ганмаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат. Дэд ажлын хэсгээс хариулъя. 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Уянга гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Эрдэнэбаяр. Ер нь бол цусны нөөцийн асуудал дээр бол Цус сэлбэлт судлалын үндэсний төв байнгын болон гамшгийн үеийн нөөц гэсэн 2 ангилалтайгаар явдаг. Яг өнөөдрийн байдлаар бол байнгын үеийн нөөцийг 10-14 хоногоор тооцож явдаг. Энэ түвшин дээрээ яг өнөөдрийн байдлаар бол хангалттай түвшинд байгаа. Гамшгийн үеийн нөөц бол бас тодорхой хэмжээнд нэмэгдүүлэх ийм шаардлага хэрэгцээ бол байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар ер нь бол гамшгийн биеийн нөөцийг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж бид нар харж байгаа.

2025 оны тоо баримтаас авч үзвэл нийт 46723 цус өгөлтийн тоо байгаа. Үүний 80 хувь нь буюу 34626 нь Улаанбаатар хотод ноогдож байгаа бол үлдсэн 20 хувь нь орон нутгийн түвшинд цус өгөгдөж байгаа. Ер нь улсын хэмжээний цус цуглуулалтыг аваад үзэхэд өдөрт дунджаар бид нар 180-250 цус цуглуулалт улсын хэмжээнд хийж байж, Улаанбаатарын түвшинд бол 150-200 хүнээс цус цуглуулж байж хэрэгцээг хангаж, тухайн нутаг дэвсгэрийнхээ цусны хэрэгцээг хангана гэж ингэж тооцоолж ажилладаг. Энэ дээрээ бас тодорхой төлөвлөгөө гаргаж, явуулын байдлаар сараар нь төлөвлөж албан байгууллагуудаар явдаг.

Мөн Улаанбаатар хотын хэмжээнд 4 цус цуглуулах төв, аймгийн орон нутгийн түвшин дээр бол 21 аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүдийн дэргэд ажиллаж байгаа цусны салбар төвүүдээр цус цуглуулах үйл ажиллагаа явагдаж байгаа. Цаашдаа бол ер нь эмнэлгийн тусламж үйлчилгээг орон нутагт бас хүргэхтэй холбоотойгоор цус, цусан бүтээгдэхүүний нөөц хэрэгцээ бол нэмэгдэнэ гэж ингэж харж байгаа. Энэ дээр бид нар бас тодорхой төлөвлөлтүүдийг гаргаж ингэж ажиллаж байгаа. Тэгээд энийг бас шийдлүүдийг гаргахад Цусны

донорын тухай дагнасан хуультай байх нь бол нэлээн онцгой ач холбогдолтой гэсэн ийм зүйл байгаа.

Ер нь бид нарт байгаа статистик тоон мэдээллээс авч үзвэл улсын хэмжээнд ер нь 170 мянган бүртгэлтэй донор байна гэсэн ийм мэдээлэл байгаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх “Ногоон байгаль” эко клубийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Өсвөр үед сурагчдыг эгнээндээ нэгтгэсэн “Ногоон байгаль” клуб улс орон даяар үйл ажиллагаа явуулдаг. Өнөөдөр Ховд аймгийн “Ногоон Байгаль” эко клубийн сурагчид маань Төрийн ордонд хүрэлцэн ирсэн байна. Хичээл сургуулийнхаа хажуугаар эх дэлхийгээ хайрлаж, мод тарьж, тарьсан модоо арчилж, ургуулж, түүнийгээ хэмжиж, үр дүнг нь үзэж бусдад уриалж, үе тэнгийн хүүхдүүддээ байгаль хамгаалах сэтгэлгээг төлөвшүүлэх зорилготойгоор ажиллаж байгаа сурагчид та бүхэн болон нийт улс орон даяар “Ногоон байгаль” эко клубийн сурагчдадаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархлаа илэрхийлье. Та бүгдийнхээ сурлагад нь өндөр амжилт хүсье. Аав ээжийнхээ, багш нарынхаа үгэнд орсон, эх дэлхий, ногоон байгалиа хайрласан сайн хүн болж төлөвшөөрэй.

Цогтбаатар гишүүндээ баярлалаа. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя. Алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Энэ хуулийн төслийг бол дэмжиж байна. Тэгэхдээ хэд хэдэн асуух асуулт байгаад байгаа юм. Энэ хууль дотор ингээд тухайн салбарын ажиллагсдын цалин, нэмэгдэл урамшууллын асуудлыг тусгаад яваад байгаа. Яагаад заавал зориуд тусгах болсон бэ гэж 1 асуулт байгаа юм.

2-т нь болохоор бол ийм эргэлтийн сан байгуулж байгаа юм байна. Тэгээд тэр эргэлтийн сангаасаа мөн адилхан ажиллагсдынхаа нэмэгдэл цалин, урамшууллын асуудлыг шийдвэрлэнэ гээд тусгачихсан байгаад байгаа юм. Гэтэл Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар Эрүүл мэндийг дэмжих сан гэж байгаа юм. Эрүүл мэндийг дэмжих сангаас бол аливаа төрлийн урамшуулал олгохыг бол хориглочихсон байгаа шүү дээ. Тэгэхээр манай энэ Цусны донорын тухай хуульд байгуулагдаж байгаа эргэлтийн сан маань ажиллагсдынхаа цалингийн асуудал, урамшууллын асуудал, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ гэж байгаа нь хэр зөв бэ гэдэг ийм 2 асуултыг асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Уг нь ажлын хэсгийн гишүүд хариулах ёстой юм. Их Хурлын гишүүд, Байнгын хороо. 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Соронзонболд гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Энэ өргөн баригдсан хуулийн төсөл дээр эргэлтийн сан гэдэг байдлаар тусгагдсан байгаа. Яг өнөөдрийн явж байгаагаар бол бид нар цус хэлбэр судлалын салбарт ажиллагсдын албан ажлын онцгой нөхцөл гэдэг байдлаар томъёолж оруулж ирж байгаа. Ер нь Монгол Улсын хэмжээнд цус сэлбэлт судлалын салбарт үндсэндээ Цус сэлбэлт судлалын үндэсний төв болон 21 аймаг, алслагдсан 2 дүүрэг, 4 нэгдсэн эмнэлэгтэй сум дээр цусны салбар төвүүд нийт 27 ийм төв хамаарагдаж байгаа. Энд бол улсын хэмжээнд ерөөсөө 206 хүн л ажилладаг. Үүний үндсэн эмч мэргэжилтнүүдийн 60 гаруй хувь нь бол Улаанбаатар хотод ажиллаж

байна. Яг 206 хүнээс хүний нөөцийн хангалт нь бол 63 хувьтай байгаа. Энэ яг цус сэлбэлтийн мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэнэ гэдэг бол өөрөө бас нэлээн асуудалтай. Цөөн хүнээр явдаг. Энэ хүмүүсийг тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэхэд энэ хууль бол бас онцгой ийм дэмжлэг болж өгнө гэж харж байгаа. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцүүлэх явцад энэ салбарт ажиллаж байгаа эмч, ажиллагсад болон бусад доноруудаас бас санал асуулгуудыг нэлээн их авч тусгаж өгсөн. Энэ дээр хамгийн их олон санал өгсөн саналаар бол энийг онцгойлон анхаарч, энэ хуульд тусгаж өгөөч гэдэг ийм хүсэлтүүд орж ирсэн байж байгаа.

Ер нь нөгөө цусны онцлог бол өөрөө энд ажиллаж байгаа хүмүүс бол 1 дүгээрт тогтвортой ажиллахын тулд сургагдаж бэлтгэсэн байх ёстой. Тэгээд энэ хүнийг нөөцийг тогтвортой ажиллуулах хамгийн их чухал байгаа.

2 дугаарт нь ажлын нөхцөл өөрөө бол цустай ажилладаг, тухайн ажиллаж байгаа хүмүүсийн эрүүл мэндэд бас ийм нөлөөллүүд бас байдаг гэсэн судалгаанууд байдаг. Сийвэнгийн бүтээгдэхүүнийг гэдэг юм уу -86 градуст хадгалдаг байгаа. Тэгэхээр энэ хүйтэн орчинд ажилладаг гэдэг юм уу яг энэ цэрэг, цагдаа, онцгой байдлын гээд бусад холбогдох ажилтнуудтай бас ер нь их дөхүү нөхцөл дээр байдаг юм байна гэдэг ийм зүйлийг бас энэ хэлэлцүүлгийн явцад бас гарч ирж ингээд бас хуулийн төсөл дээр албан ажлын онцгой нөхцөл гэдэг байдлаар тусгаж оруулсан байгаа.

С.Бямбацогт: Соронзонболд гишүүн тодруулж асууя.

Л.Соронзонболд: Би ойлгож байна. Тэр Засгийн газрын тусгай сан дотор чинь Эрүүл мэндийг дэмжих сан гэж байгаа шүү дээ. Тэндээс бол ямар нэгэн урамшуулал олохыг хориглочихсон байгаа байхгүй юу хуулиар. Та бүхэн болохоор тусгай сангийн хүрээнд эргэлтийн сан байгуулаад явах гэж байна шүү дээ тэр хуулийн дагуу. Тэгээд тэр сангаасаа ийм асуудал шийдэх гээд. Гэтэл тухайн байгууллагуудын чинь ажиллагсдын цалин хөлсний асуудлыг тэртээ тэргүй төсөв дээр суулгаж байгаа. Ажлын байрны нөхцөл байдлыг нь харгалзаж үзээд цалинг нь ялгаатай тогтоох боломж нь бусад хууль тогтоомжоороо байгаа байхгүй юу. Тэгээд би зүгээр яагаад зориуд ингэж авсан юм бэ гэж.

2-т болохоор зүгээр уншихаар энэ цусны донор маань сайн дурын бөгөөд авлагагүй байх гээд нэг ийм зарч зарчим байгаад байгаа. Тэгэхээр авлагагүй байх гэдэг зарчим бол бас яг хүн ингээд уншихаар жоохон ойлгомж муутай. Энийг бас зүгээр санал хэлж байгаа юм шүү. Жоохон ойлгомжтой байдлаар тайлбарлавал зүгээр юм болов уу гэсэн ийм санал хэлчихье.

С.Бямбацогт: Ажлын хэсэг эцсийн хэлэлцүүлэг дээр анхаарчхаарай. Санал хэлж байна. Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуултаа асууя.

М.Энхцэцэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Донорын хуулийг бол дэмжиж байгаа. Энэ бол үнэхээр маш чухал эрүүл мэндийн салбарын бол тулгамдсан асуудлын нэг байгаа. Энэ дээр би 2 асуулт асуумаар байна л даа.

Нэгдүгээрх нь ер нь донорыг зөвхөн санхүү гэхээсээ илүүтэй эрүүл мэндэд нь шинжилгээнд хамруулах ч гэдэг юм уу, бүр яаралтай хүнд байдалд орсон, эмнэлэг дээр очсон донорыг арай жоохон өөр нөхцөлөөр ч гэдэг юм уу ингэж дэмжих,

урамшуулах чиглэл рүү ямар бодлого, ямар зохицуулалт энэ хуульд орж байгаа вэ. Тухайлбал, манай эгч бол бас хүндэт донор. Насаараа донор болоод цусаа хандивлаж байсан ийм хүн. Маш хүнд, бараг харвалт өгөөд ингээд эмнэлэг дээр очсон. Тэгээд хүлээгээд маш хүнд байдалтай байсан. Тэгээд хүүхдүүд нь бас насаараа донор байсны юу чинь хаана байгаа юм бэ гээд бас асууж байсан. Тэгэхээр иймэрхүү байдал.

2 дугаар асуудал болохоор ер нь бол мэдээж цусаа хандивлах хүсэлтэй олон хүмүүс байдаг. Гэхдээ яг үнэхээр зориод эмнэлэг дээр очоод цусаа өгчих тэр цаг завтай хүмүүс бас ховор байдаг. Тийм учраас олон улсад ч гэсэн байгууллага дээр очиж, цус хандивлах том хэмжээний аяныг жилдээ 1 удаа ч юм уу зохион байгуулах тийм юм нь Донорын тоог бол бараг 3, 4 дахин өсгөдөг гэсэн ийм судалгаа байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ талаар бас ямар нэгэн зохицуулалт хууль дээр суусан уу. Энэ бол бас бас нэлээн үр дүнтэй арга. Дээрээс нь бас цусаа хандивлах гэсэн хүмүүсийг нээж илрүүлэх, шинэ доноруудыг нээж илрүүлэх ийм үйл ажиллагаа байж болох юм гэж ингэж бодож байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Ер нь бол энэ сайн дурын авлагагүй гэдэг энэ томьёоллууд бол олон улсад байдаг ийм томьёоллууд байж байгаа. Одоо хүчин төгөлдөр байгаа Дорнын тухай хууль дээр бас яг энэ нэр томьёоллоороо ингэж явж байгаа. Тэгэхээр энэ бол бид нар бас тухайн хэл зүйн талаас нь асууж, ярилцаж тухайн үедээ одоо бас ингэж оруулж байсан энэ нэр томьёо бол энэ чигээрээ явж байгаа. Ер нь бол энэ өөрөө Цусны дорнын тухай хуулийн гол амин сүнс нь сайн дурын авлагагүй байх гэдэг зарчим байгаад байгаа. Үүнтэй холбоотойгоор таны асуусан энэ урамшууллын асуудлууд бас байгаад байгаа юм. Цусаа олон удаа өгсөн хүмүүсээ яаж дэмжих вэ гээд. Ер нь зүгээр энэ хуулийн хэлэлцүүлгийн явцад бол бас энэ талаар таны яг хэлсэн томьёоллоор тусгагдсан байсан боловч зарчимтайгаа бас тодорхой хэмжээний зөрчилдөөд байгаа учраас энийг оруулахгүйгээр, дүрэм журмын зохицуулалтуудаа хийе гэдэг байдлаар явсан байж байгаа.

Явуулын хэлбэрээр цус цуглуулах гэдэг бол албан байгууллагуудаар явж цус цуглуулах үйл ажиллагааг бол ажлын өдөр болгон хийгдэж байгаа. Энэ үйл ажиллагаа бол нийт цус цуглуулалтын 40 хувийг эзэлдэг ийм онцлогтой. Тэгээд энийг бол ЦССҮТ бол яг Улаанбаатар хотын хэмжээнд 1-2 сараар ингэж төлөвлөөд, өөрөөр хэлбэл тухайн донор цусаа өгөхийн тулд бас тодорхой хэмжээний бэлтгэл хангасан байх ёстой зүйл байдаг. Сайн унтаж амарсан байх ёстой. Хүнд төрлийн хоол идэхгүй байх ёстой. Өглөө нь өнгөтэй сүү гэдэг юм уу, жүүс хэрэглэхгүй байх гэдэг юм уу, архи, согтууруулах ундааны ундааны зүйл 72 цагаас дотор хэрэглээгүй байх энэ тэр гээд маш олон ийм шаардлагууд байдаг. Нөгөө талаас нь цусны аюулгүй байдлыг хангах хүрээнд сонгож байгаа донор дээр олон шалгуур үзүүлэлтүүд байдаг. Яагаад гэвэл бид нар эрүүл хүнээс, харьцангуй эрүүл хүнээс цус цуглуулж байж энэ бол эмчилгээний бүтээгдэхүүн болох учраас энэ нэлээн их шалгуурууд байдаг. Энэ шалгуурын дагуу тухайлбал, нийт ирж байгаа доноруудын бас 30-35 хувь нь бол хасагдаж байна гэдэг ийм бас тоон баримт байгаа. Энэ нь яаж байна вэ гэхээр хүн ардын дунд, хүн амын дунд цусны донорын талаарх мэдлэг хандлага, дадал сул бол байна. Тийм учраас энийг бас зохицуулах, үүний санхүү, урамшуулал зэрэг асуудлуудыг энэ хуульд тусгаж өгөх нь хамгийн чухал байгаад

байгаа учраас Цусны донорын тухай хууль дээр энэ асуудлыг бол нэлээн тодорхой тусгаж өгч, зарим журмаар зохицуулдаг зүйлийг яг хуульчилж оруулж ирж байгаагаараа бас онцлог болж байгаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Жанчивын Галбадрах гишүүн асуултаа асууя.

Ж.Галбадрах: Та бүхний энэ өдрийн амгаланг эрье. Хүний эрүүл мэнд, амь настай холбоотой чухал хууль учраас дэмжиж байгаа. Тэгээд 2, 3 санал, 2, 3 асуулт байна.

4 дүгээр зүйл дээр зарчмыг бичсэн байсан. Тэр зарчим дээр ийм зүйл нэмэх саналтай байна. Цус, цусан бүтээгдэхүүний тэгш хүртээмжийг хангах гэсэн цусан бүтээгдэхүүн буюу плазм гэж ярьдаг. Энэ зүйлийг бас ингэж оруулж ирж тэгш хүртээмжийг нь хангах гэсэн зарчмыг оруулах нь зүйтэй байна гэж бодож байна.

Гишүүд бас их ярьж байна. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын бодлого бол 100 хувь сайн дурын, авлагагүй донорын тогтолцоо. Нөгөө талаас цусны аюулгүй байдал, үндэсний нэгдсэн систем гэсэн ийм 3 тулгуур дээр бол үндэслэсэн байгаа. Тийм учраас тэр хуулийн төслийн 17.1-д цусны донорын үүргээ гүйцэтгэх үедээ Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор авах гэж заасан нь бол энэ зарчимтай бол зөрчилдөөд байгаа. Энийг хэлж байна. Ийм учраас нөхөн тэнцэх олговор гэхээсээ илүү тухайн үйл ажиллагаанд оролцсонтой холбоотой шууд зардлыг нөхөх хэлбэрээр тийм дэмжлэг үзүүлбэл ямар байсан юм бэ. Өөрөөр хэлбэл зөвхөн нөхөн олговор, хоол юм уу, унаа шууд гарч байгаа зардалтай нь холбоотой нийт донорт тэгш үйлчлэх энэ зарчмаар байх хэрэгтэй. Тэгэхгүй бол хөдөлмөр эрхэлдэг хүмүүс нь энэ боломжийг хүртээд, хөдөлмөр эрхлээгүй донорт бол энэ зохицуулалт бас зохицохгүй байна уу гэж ингэж харж байна.

Нөгөө талаас дараагийн асуулт бол 27 дугаар зүйлд байж байна. Донорын үйл ажиллагааны журам зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар бичсэн байгаа. Тэгээд энэ юуг зөрчсөн бол тэр 27.1, 27.2-т нь бол зүгээр зөрчсөн албан тушаалтан болон хүмүүст холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэх гээд их тодорхойгүй биччихсэн харагдаад байгаа. Тэгэхээр ямар хуульд заасан, ямар хариуцлагыг хэн хүлээлгэх талаар тодорхой болгох боломж байгаа юу. Эрүү, Иргэний, захиргааны ямар хариуцлага хүлээлгэх вэ. Магадгүй эмчийн ёс зүй, эмнэлгийн байгууллагын ажилтны ёс зүйн хариуцлага ч байж болох талтай. Тэгээд энэ цаашлаад бүр тусгай зөвшөөрөлтэй нь ч гэсэн ярих гэдэг энэ асуудал байна. Тэгээд үүнтэй холбоотойгоор 1 асуулт байна. Энэ бол тусгай зөвшөөрөл олгох шалгуур, шаардлага энэ хуульд туссан уу. Тусаагүй бол яагаад вэ. Тэгээд ямар шалгуур хангасан байгууллагууд тусгай зөвшөөрөл өгөх юм бэ. Ер нь энэ тусгай зөвшөөрлийг хэн, хаана, ямар байгууллага олгодог вэ гэдэг ийм асуулт байна.

Дараагийн 1 зүйл бол цусны түгээлт, хадгалалт ямар түвшинд байдаг вэ гэдэг талаар асуумаар байна. Нийслэлд түгжрэлтэй үед бол бид нар Эх нялхсын төв ч юм уу, тэр Япон, Монголын эмнэлэг, Яармагийн эмнэлгүүд энэ тэр дороо ашиглаад яваад байгааг бол сонсож мэдэж байсан. Тэгэхээр энэ орон нутагт ер нь энэ тээвэрлэлт нь ямар байдалтай, яаж зохицогдож байдаг юм бэ гэдэг ийм асуултууд асууя. Баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Галбадрах гишүүний асуултад хариулъя. Ер нь бол энэ хууль дээр тусгаж өгснөөр ажлаа хийж байгаа хүн бол тухайн цусаа өгсөн өдрөө ажилласанд тооцох байдлаар ингэж тусгаж өгсөн байж байгаа. Өөрөөр хэлбэл цалингаа авах байдлаар ер нь бол шууд санаа нь бол тэгж тусгаж өгсөн байгаа. Хэрвээ ажил хийдэггүй, хувиараа хөдөлмөр эрхлэх гэдэг юм уу ийм хүмүүс дээр бол илчлэг нөхөх хоол хүнсний асуудлуудыг бас яг хуульд тусгаж оруулж өгсөн байгаа. Ер нь энэ дээр ажил хийж байгаа, хийхгүй байгаа хүмүүс дээр хөдөлмөрийн харилцаанд орж байгаа эсэхээсээ хамаараад бас зохицуулалтууд нь ингэж тус тусдаа байхаар бид нар тооцож өгсөн. Тэгээд яг одоогийн байдлаар бол 1 хүнд тооцох илчлэгийн хэмжээ яг өнөөдрийн төсвийн байдлаар бол 8900 төгрөг байгаа. Тэгэхээр энэ бол хангалтгүй байна гэдэг тооцоолууд хийгдсэн. Тэгэхээр энийг бид нар бас яг энэ хууль дээр зааж оруулж өгснөөр бас тодорхой хэмжээнд нэмэгдэж өгнө буюу өөрөөр хэлбэл тухайн хүн цусаа өгөөд алдаж байгаа энергийг нөхөх энэ боломжуудыг бүрдүүлж өгнө гэж ингэж харж харж байгаа.

Энэ тусгай зөвшөөрөл гэдэг дээр одоо яаж байгаа вэ гэхээр магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага бол цус авах, үйлдвэрлэх, шинжлэх, тэгээд олгох энэ үйл ажиллагаануудыг бол яг ийм зөвшөөрөл авсан байгууллагууд гүйцэтгэнэ гэдэг байдлаар томъёологдож орж ирж байгаа. Яг тусгай зөвшөөрлийн тухай хууль дээрээ бол яг энэ тухайлсан заалтууд бол байхгүй байгаад байгаа.

Улаанбаатар хотын түгжрэлтэй холбоотой маш их асуудлууд гарч ирдэг. Ялангуяа яаралтай үеийн цус, цусан бүтээгдэхүүн шаардлагатай үед үнэхээр цусыг түгжрэлтэй үед яаж хүргэх вэ гэдэг асуудал бол нэлээн их тулгамддаг. Энэ дээр Цус сэлбэлт судлалын үндэсний төв 2020 оноос хойш төсөл хэрэгжүүлээд, дроныг бас энэ үйл ажиллагаандаа нэвтрүүлж, өнөөдрийн байдлаар 14 эмнэлэг дээр дроныг ашиглах боломжуудыг бүрдүүлж ажиллаж байгаа. Ер нь энэ жилдээ багтаагаад 40 эмнэлэг дээр хүргэнэ гэсэн ийм тооцоолуудыг хийж байгаа. Тэгэхээр ингэснээрээ бол маш богино хугацаанд нэг талдаа хийсэн судалгаагаар бол 30-40 минутад дунджаар хүргэж байгаа цус, цусан бүтээгдэхүүнийг ер нь бол 6-8 минутад хүргэх боломжтой хүрэх боломжтой байна гэдэг ийм давуу талууд гарч ирсэн. Энэ дээр бол бас нэлээн ахиц гарч, ингэж тээвэрлээд явж байгаа. Орон нутгийн түвшинд бол тухайн орон нутагт байгаа цусны салбар төвүүд бол тухайн орон нутгийнхаа хэмжээний цус, цусан бүтээгдэхүүнийг хангадаг байгаа. Ялангуяа сумын түвшинд гэдэг юм уу, хөдөө хээр бас тохиолдлууд бас гардаг. Төрөлтүүд, төрөлтийн хүндрэл, цус алдалтын хүндрэлүүд гардаг. Энэ үед бол цус, цусан бүтээгдэхүүн тээвэрлэх, донорыг авч явж, газар дээрээ түргэвчилсэн шинжилгээний байдлаар бас энэ асуудлуудыг шийдвэрлэх байдлаар одоо явж байгаа. Цаашдаа ингээд хууль батлагдаад явахаар орон нутгийн цусны салбар төвүүдийг илүү үйл ажиллагааны хувьд нь бэхжүүлэх ийм хэрэгцээ шаардлагууд байгаа. Яг орон нутагт шаардлагатай үед Улаанбаатар хотоос бас онгоцоор гэдэг юм уу, галт тэргээр, ойролцоо байгаа газрууд дээр бол автомашинаар гэх байдлаар бас тээвэрлэлтүүдийг тодорхой тавигдаж байгаа стандартын шаардлагын дагуу сав, баглаа боодлыг хийж, орчин нөхцөлийг нь бүрдүүлж ингэж тээвэрлэдэг байгаа.

С.Бямбацогт: Галбадрах гишүүн тодруулж асууя.

Ж.Галбадрах: Хариуцлага тооцох талаар их тодорхойгүй. Холбогдох хууль журмын дагуу л гэгчээд байгаа. Тэд нарыг тодорхойлох талаас.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Галбадрах гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ хариуцлагын асуудал бол хамгийн чухал асуудал байж байгаа. Энэ дээр бид нар яах вэ, Төрийн албаны тухай хууль дээр энэ ёс зүйн асуудлууд бас ингээд тусгагдчихсан байгаад байгаа учраас яг энэ хуулийн томъёолол дээрээ Төрийн албаны тухай хууль гэдэг байдлаар оруулаад өгсөн. Энэ дотроо бол бас таны түрүүн хөндсөн ёс зүйн асуудлууд ингэж орж байгаа. Тухайн хүний амь нас, эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулсан үед бол Эрүүгийн хуулиар зохицуулахаар яг энэ хуулийн төсөл дээр бол ингэж тусгагдаж өгсөн байгаа. Өнөөдрийн яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм журмын хүрээнд бол ёс зүйн асуудлууд бол бусад хууль журмын хүрээнд зохицуулагдчихсан байгаа учраас энэ дээр давхар тусгаж өгөөгүй байгаа.

С.Бямбацогт: Гомбын Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Энэ чухал хууль. Тэгээд энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Энэхүү хууль батлагдан гарснаар цус, цусан бүтээгдэхүүний нөөц хангамжийн тасралтгүй байдлыг хангахад ихээхэн тус дэм болно гэж үзэж байгаа. Энэ 3 гол зүйл байгаа юм болов уу гэж энэ хуулиас харсан.

1 дүгээрт нь тэр цусны аюулгүй байдал,

2 дугаарт нь цус, цусан бүтээгдэхүүний нөөцийн тогтвортой байдал

3 дахь нь тэр цусны энэ идэвхтэй доноруудын нийгмийн баталгаа нь бас чухал юм уу гэж. Тэгэхээр тэр 3 дахь асуулт дээр түрүүний гишүүдийн асуултад хариулж байхад манай улсад 170 мянга орчим цусны идэвхтэй донор байдаг бололтой юм. Ярианаас чинь сонсож байлаа. Бодвол байнгын бүртгэлтэй л байдаг байх л даа. Гэхдээ бас тэрнээс ирсэн донорууд, цус өгч байгаа хүмүүсээс 30-35 хувь нь бас шаардлага хангадаггүй бололтой гэх шиг боллоо. Тэгэхээр энэ цусны идэвхтэй доноруудынхаа нийгмийн баталгаа талаас бол энэ хуулийн 20 дугаар зүйл дээр тодорхой 2, 3 зүйл орсон л байна л даа. Энэ хуучин ч байсан юм. Би Дорноговь аймгийн Хурлын дарга хийгээд, аймгийн Улаан загалмайн нийгэмлэгийг удирдаж байх үед л Улаан загалмайн хүндэт донор ч билүү тэмдэг өгдөг, жилдээ 1 сувилалд явах эрх. Гэхдээ эргээд энэ цусаа өгч байгаа хүмүүс автобусаар зорчих, нийтийн тээврээр үйлчлэх гээд ийм 3 зүйл байх шиг байдаг юм. Бас ер нь энэ цусныхаа нөөц, идэвхтэй доноруудынхаа нийгмийн баталгаа чиглэлээр, хэдийгээр сайн дураар өгөх ёстой ч гэсэн ахиад энэ хууль дээрээ бас арай өөр нэмэлт баталгаанууд оруулж ирж болоогүй юу. Тэр хүндэт донор ч гэнэ үү, сувилалд жилдээ 1 удаа амардаг билүү, өөр бусад улсын жишиг ямар байдаг юм бол. Харж байхад маш олон донор болсон хүмүүс насныхаа эцэст эрүүл мэндийн үйлчилгээгээ ч авч чаддаггүй, эмнэлэг домнолгоор явахад ямарваа нэгэн хөнгөлөлттэй зүйл харагддаггүй байсан. Энд бол яах вэ, 1 заалт нь тэр эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх гээд ерөнхий заалт, жилд 1 удаа эрүүл мэндийн төлбөрт хамрагдах гээд тэр 21.3.2 дээр орсон байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх гэдэг нь яг ямар заалтыг хэлж байгаа вэ. Их тодорхой хэлээд, энэ нийгмийн баталгаа талаасаа энэ хууль дээр орсон гол өөрчлөлтүүдээ хэлээд өгнө үү.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон дээр ажлын хэсэг хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Үнэхээр энэ байнгын доноруудын тоо, хувийг нэмэгдүүлэхийн тулд энэ хүмүүсийг урамшуулах асуудлууд бол хамгийн чухал байдаг. Олон улсын ч гэсэн сайн туршлагауд бол байдаг. Тэгээд энэ дээр таны түрүүний дурдсанчлан сувилалд 1 удаа үнэгүй амарч байгаа. 35-аас дээш удаа цусаа өгч, хүндэт донор болсон хүмүүс бол ийм зохицуулалт байгаа. Нийтийн тээврээр бас үнэ төлбөргүй явж байгаа. Шагналын асуудлыг бас бид нар нэр хүндийг нь өсгөх байдлаар энэ хууль дээр шинээр томъёолж өгсөн. Өөрөөр хэлбэл Засгийн газрын шагнал буюу Эрүүл мэндийн сайдаас олгодог байдлаар ингэж бас томъёолж өгсөн нь эргээд бас доноруудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ гэж бид нар харж байгаа. Тухайн донорууд нийслэлийн хэмжээнд цусаа өгч байгаа доноруудыг бол Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, орон нутагт бол бас тухайн аймгийн Тамгын газрууд дээр нийгмийн дэмжлэг үзүүлэх гэдэг байдлаар бид нар тусгаж өгсөн. Яг тухайлсан заалтууд ороогүй. Байгууллагаараа цусны донорын эгнээнд хамрагдаж байгаа энэ байгууллага хамт олныг уг нь бол бас татварын хөнгөлөлт гэдэг ийм зүйлүүд орж ирсэн саналууд байсан боловч бусад хуулиуд байсан боловч бусад хуулиудтайгаа нийцэхгүй байна гээд гэдэг байдлаар яг ажлын хэсгийн хэлэлцүүлгийн явцад энэ асуудал ингэж байхгүй байдлаар ингэж томъёологдсон.

Одоо хүчин төгөлдөр байгаа хууль дээр эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлнэ гээд Эрүүл мэндийн сайдын тушаалаар журам гараад, шинэчлэгдээд, батлагдаад мөрдөгдөөд явж байсан. Гэхдээ 2020 оноос эхлээд эрүүл мэндийн салбарт гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоо нэвтэрсэнтэй холбоотой энэ асуудал маань үнэхээр энэ даатгалын тухай хуультайгаа зөрчилдөөд эхэлсэн. Тийм учраас шинэ Цусны донорын тухай хууль дээр бол яг энэ эмнэлгийн хөнгөлөлттэй үйлчилгээ гэдэг асуудал бол энэ хуультай зөрчилдөөд байгаа учраас бас тусгагдахгүй байдлаар томъёологдож ингэж явж байгаа.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Энэ хуулийн 21 дүгээр зүйл чинь нөгөө цусны донорт дэмжлэг үзүүлэх гээд. Тэгээд би 21.3.2-ыг л асуугаад байна л даа. Та сая бараг энэ 3.2 дугаар заалт бараг хэрэгжихгүй бололтой юм ярьчихав уу. 21.3.2 чинь эмнэлгийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх гээд заачихсан. Тэр жилд 1 удаа эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамрагдах, ялангуяа тэр эхнийх нь заалт болохоор хэрэгжихгүй болж байгаа юм уу. Тэгээд энэ хуулийн төсөл дээр ч уг нь биччихсэн байна л даа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Ганбаатар гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ өргөн баригдсан хууль дээр гишүүн ээ, ийм байдлаар томъёологдож орж ирсэн. Яг өнөөдрийн байгаа төсөл дээрээ бол ийм байдлаар байхгүй байгаад байгаа юм. Энэ

эхний Их Хурал дээр өргөн барих үед, тэгээд ажлын хэсэг дээр энэ дээр бас ингээд өөрчлөөд ороод явчихсан байж байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг зассан юм байна. Тийм ээ.

Н.Эрдэнэбаяр: Тэгсэн.

С.Бямбацогт: Пүрэвийн Батчимэг гишүүн асуултаа асууя. Алга байна. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Цусны донорын тухай хуулийг дэмжиж байгаа. Хуулийн төсөлд орж ирж байгаа заалтын дагуу бол байнгын идэвхтэй доноруудын тоонд бас орж байгаа. Цус бол бас хүний амийг аврах орлуулшгүй нөөц. Монгол Улс цусны хангамжийн хомсдолтой тулгарсаар ирсэн байгаа. Цаашдаа нэмэгдүүлэхэд энэ хуулийн төслийн бас гол ач холбогдол бас оршино гэж ойлгож байгаа. Байнгын хороонд нэлээн олон асуудлууд тодруулаад асуучихсан болохоор энэ цусны донорын нийгмийн хамгаалал, цусны донорыг алдаршуулах, урамшуулахтай холбогдолтой асуудлуудыг дахиад жоохон тодруулаад, саналаа хэлчихье гэж бодож байна.

Хуулийн төсөл дээр бол цусны донорыг алдаршуулахтай холбогдолтой, ялангуяа хүндэт донор цолыг олгохтой холбогдолтой хэд хэдэн асуудлууд тусгагдаж орж ирлээ. Хуучин Улаан загалмай олон улсын байгууллагын шагнал байсан бол Засгийн газрын шагнал буюу сайдын үндсэндээ, яамнаас олгогддог ийм шагнал болгож оруулж ирж байгааг дэмжиж байгаа.

Энэ дээр бид бас сайн дурын, авлагагүй өглөг гэдэг талаас нь хараад жоохон гар татаад байгаа юм шиг санагдаад байгаа юм. Шалгуур үзүүлэлтүүдийг нь өмнөхөөсөө арай жоохон ахиулчхаж байгаа. 7, 8 жил тасралтгүй цусаа өгч байж бас энэ болзлыг хангах нэлээн ийм өндөр шалгууртай болгочихсон байгаа юм. Бусад улс орнуудын жишээ мэдээллийг та хэд маань тодруулж ирээрэй гээд би Байнгын хороон дээр асууж байсан. Ирланд жишээ нь гэх юм бол тодорхой шатлалтай тогтолцоог нэвтрүүлээд, донорын тоо 2 дахин нэмэгдсэн ийм сайн туршлагууд бас байгаа юм байна. Сингапур, мөн хэд хэдэн улсууд бол шатлалтай ийм тогтолцоог нэвтрүүлсэн байгаа юм байна. Тэгэхээр ажлын хэсэг дээр тодорхой бас саналуудыг дэвшүүлээд, 5, 10, 15, 20 удаагийн байдаг юм уу өгсөн энэхүү донорын идэвхийг бас үнэлдэг ийм шатлал руу оруулбал яасан юм бэ гэсэн ийм саналтай байгаа юм. Тэгээд энэ талаар та хэд маань бас судалж үзсэн үү. Яагаад заавал ингээд хатуу 25 болон түүнээс дээш удаа гэдэг байдлаар оруулж ирж байгаа вэ. Тэгээд энэ дээр ийм уян хатан хандах нь зөв байна гэдэг эхний ийм асуулт байгаа.

2 дахь нь зөвхөн хувь хүнээс гадна бас байгууллага хамт олноороо, гэр бүлээрээ идэвхтэй байгаа байдлыг нь бид нар бас дэмжих ийм санаачилгууд байж болох уу. Тэгээд энэ чиглэлийг дэмжсэн агуулгыг энэ хуулийн төсөлд оруулж ирж болох уу. Энэ нь бол төсөв, санхүү зардал гэлгүйгээр зөөлөн аргаар тодорхой бас үр дүнд хүрч болох ийм туршлагууд байгаа учраас энэ дээрээ нэлээн ийм уян хатан хандаад явчих нь зөв юм болов уу гэсэн ийм саналтай байна. Тэгээд тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Ганхүлэг гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Цусны хүндэт донорын асуудал бол 1962 оноос эхэлж Монгол Улсад олгож эхэлсэн. Анх 1962 онд бол 4 литр цусаа бэлэглэсэн бол хүндэт донор өгдөг байсан. Дараа нь энийг бас шинэчлээд 8 литр болгож нэмэгдүүлсэн байж байгаа. Ингээд 2000 оноос ер нь энэ дээр бас одоо мөрдөгдөж байгаа хүндэт донор дээр бол 30 удаа бүхэл цус, 35-аас дээш удаа цус болон цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн хүмүүст Хүндэт донор гэж шагналыг олгож байгаа.

Бид нар олон улсын жишгүүдийг харж ирсэн байгаа. Одоо яг шинээр энэ хууль дээр бол бид нар 50-аас дээш удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн бол гэдэг байдлаар томьёолж өгсөн. 1 дүгээрт.

2 дугаарт бол шагналын нэр хүндийг өсгөх байдлаар Засгийн газрын шагнал гэдэг байдлаар ингэж томьёолсон. Таны түрүүний дурдаж байгаа улсууд дээр бол өгөлтүүд, ялангуяа тэгш өгөлтүүд дээр тэмдэг олгодог ийм асуудлууд байгаа. Тэгээд энийг бид нар бас хууль дээрээ Цус сэлбэлт судлалын үндэсний төв дээр энэ эрхийг нь олгож өгсөн байгаа. Ялангуяа 9 дүгээр зүйл дээр тэмдэг олгож болно гэдэг байдлаар заасан. Тэгэхээр бахархалт тэмдгүүд болон алт, мөнгө, хүрэл, донор, топ донор гэсэн энэ зүйлүүд бол 2019 оноос хойш яг үйл ажиллагаандаа мөрдөөд явж байгаа. Одоо бол яг хуульчилж өгч байгаагаараа бас онцлог буюу нэр хүндийг өргөх тал дээр нь нэлээн их дэмжлэг болж өгч байгаа гэдэг ийм асуудал байж байгаа.

Мөн гэр бүлийн донорыг урамшуулах асуудлуудыг бол тухайн орон нутгийн засаг захиргаа бол нэлээн их анхаардаг. Ялангуяа гэр бүлийн өдрөөр 5 сард бол 9 гэр бүлийн донорыг алдаршуулах гэдэг ийм үйл ажиллагаанууд бол уламжлал болж явдаг байгаа. Тэгээд таны саналыг бас бид нар ажлын хэсэг дээр яриад, яг хууль дээр бол ингэж тухайлан тусгаж өгөөгүй байгаа учраас энийг дараагийн хэлэлцүүлэг дээр ажлын хэсэг дээр ярих боломжтой гэж ингэж бодож байна.

Энэ 50 гэдэг тоог гаргаж ирэхэд бол манай 2 хөрш орон БНХАУ, ОХУ-д ямар байна вэ гэхээр энэ нь 40-60 гэдэг ийм тоонууд байдаг юм байна лээ. Тэгээд ялангуяа ОХУ дээр бол Хүндэт донор буюу почётный донор гэсэн ийм нэр томьёонууд бол байгаа. Бусад улсуудад тухайн улсынхаа онцлогоос хамаараад нэр томьёонууд нь бол өөр өөр байгаа. Тухайлбал Герман улсад бол яг хүндэт донор гэдэг байдлаар явдаггүй. Манай яг өгөлттэй адилхан 10, 25 удаа, 50, 75, 100 гээд 25-ын хэлбэлзэлтэйгээр ингээд урамшуулаад явдаг байгаа бол Австралид бас 10, 25 гэдэг байдлаар явдаг ийм бас зүйлүүд бид нар бас олон улсын туршлагаудыг судалж байгаад энэ тооцооллыг гаргаж ирсэн байгаа.

С.Бямбацогт: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: ОХУ хэчнээн хүн амтай билээ, Хятад улс бас хэчнээн хүн амтай билээ. Бас мэдээжийн хэрэг тэр чинь бас цус өгч байгаа хүмүүсийн тоо энэ тэр нэлээн олон л байгаа байх л даа. Тэгэхээр бас илүү ижил төстэй улс орнуудтай харьцуулах, тэгээд энэ яг энэ 20 дугаар зүйл дээр байгаа зөвхөн Хүндэт донор гэж байгаа энэ ангиллыг илүү шатлалтай болговол ямар вэ гэдэг ийм саналыг л дэвшүүлээд байгаа юм. Тэгээд дараа дараагийн хэлэлцүүлэг дээр бас боломжтой бол та бүхэн маань бас энэ саналыг бас ярилцаж үзээч ээ гэдэг ийм санал бас хэлье.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Жамбын Батсуурь гишүүн асуултаа асууя.

Ж.Батсуурь: Цусны донорын тухай хуулийн төсөл болгон үүнтэй хамт өргөн мэдүүлж байгаа хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Энэ бол маш буянтай, хүний амь аврах энэрэнгүй сайхан хууль гэж ингэж үзэж байгаа. Мэдээж өмнөх хариулт асуултууд дээрээс бол олон зүйлийг мэдэж, ойлгож авсан. Энэ орон нутаг, хот хоорондын зам их ачаалалтай байгаа замуудыг дагасан сум суурин газруудад цус цуглуулах үйл ажиллагаа ер нь ямар байдаг юм бол.

2-т гэвэл түүнийг хадгалах стандарт нь олон улсын горим шаардлагад хангагдсан байдаг уу, үгүй юү гэж. Цаашилбал бүр хилийн бүс нутаг, боомт газруудад хүнд тээврийн машин унаа их явдаг. Энэ хот хоорондын замд бол хурд хэтрүүлснээс бас маш хэцүү том том аваарууд гардаг. Орон нутагт бас аймаг удирдаж байхад бол автобус, хүн олноороо явж байгаа тээврийн хэрэгсэл ачааны машинтай мөргөлдөх ч гэдэг юм уу ийм нөхцөл байдлууд бол бий болдог. Ингэхэд сум, суурин газрууд энэ хот хоорондын замыг дагасан, боомтын замыг дагасан ийм бэлдэц нөөц бол маш муу байдаг. Бэлдэц нөөц нь донор нь байдаг юм гэхэд тэрийг хадгалах стандартын шаардлага хангах ийм найдвартай нөхцөл байдлыг хангах тал дээр бодлого нь энэ хуульд яаж сууж өгсөн бэ. Энийг дэмжих механизм нь юу вэ гэсэн ийм зүйлийг хэлмээр байгаа юм.

Дээр нь мэдээж маш олон хүмүүс донор, хүндэт донор энэ зүйлийг хийж, олон хүний амь нас амардаг. Залуу доноруудыг бэлтгэх, хүүхэд ахуйгаасаа энэ донор болох хүсэл эрмэлзлийг төрүүлэх энэ үзэл санааг хүүхдүүд төрүүлэх боломж нь энэ хуульд яаж суусан байдаг юм бол. Жишээ нь бид бүхэн бол оюутан байхдаа цусны донорыг бол маш олон удаа өгч байсан. Бидний үеийнхэн бол тэр үйл ажиллагаанд бол их хамрагдаж байсан. Тэгээд тэр үедээ бол бас хоол унд идээд, бас 5, 3 төгрөг аваад, мөн урамшуулал энэ тэр ингэж авдаг байсан. Тэгэхээр энэ оюутан залуучууд, залуу үеийг мөн цэрэг армид ажиллаж байгаа хүмүүс гээд бие бялдар сайтай, эрүүл энэ донорыг илүү өргөтгөхөд нөхцөл байдал нь энэ хуульд яаж суусан байгаа вэ гэсэн энэ асуултуудад хариулт авъя гэж бодож байна. Ингээд энэ хуулийг бол бас хурдан баталж, үйл ажиллагаанд нь оруулах нь зүйтэй гэж ингэж үзэж байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон. Батсуурь гишүүний асуултад хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Сум суурин газрууд дээр бид нар 21 аймаг, 4 томоохон нэгдсэн эмнэлэгтэй сумууд дээр бол цус цуглуулах төвүүд ингэж байгуулагдаж ажиллаж байгаа. Ялангуяа 2025 онд бид нар Замын-Үүд суманд Эрүүл мэндийн яамнаас барьж байгаа бодлогын хүрээнд цус цуглуулах төвийг байгуулсан байж байгаа. Цусны салбар төвийг. Ер нь цаашдаа бол бид нар баруун бүс дээр бас ийм төв байгуулах боломжтой юм байна. Ялангуяа Ховдын Булган сум дээр гэдэг байдлаар тооцоолж, хүний нөөцийг бэлтгэж ингэж явж байгаа.

Зарим нэг хүн ам төвлөрсөн тухайлбал, Өмнөговь гэдэг юм уу ийм аймгууд дээр бол үнэхээр таны ярьж байгаа ийм асуудлууд бас гарах зүйлүүд бас байдаг. Тэгэхээр энэ дээр бид нар яаж байгаа вэ гэхээр ер нь явуулын хэлбэрээр цус цуглуулж, тэнд байнгын донорууд, цусаа өгч байгаа доноруудын бүртгэлийн санг

баяжуулах ажлуудыг бас бодлогын хүрээнд жил болгон зохион байгуулж явдаг байж байгаа. Өөрөөр хэлбэл алсын цус явуулъя гэж зохион байгуулдаг. Цус, цусан бүтээгдэхүүний 1 онцлог бол цуглуулчхаад тодорхой хугацааны дараа хугацаа нь дуусчихдаг. Тухайлбал ялтас эсийн бүтээгдэхүүнийг бол ерөөсөө 3-7 хоног л хадгалах боломжтой. Хадгалах нөхцөлөөсөө хамаараад. Улаан эсийн бүтээгдэхүүнийг бид нар 42 хоногоос дээш хадгалж болдоггүй дэлхий нийт дээр. Мөн сийвэнгийн бүтээгдэхүүнийг урт хугацаанд хадгалах ийм боломжууд байгаа. Тэгэхээр аймгууд дээр бол сийвэнгийн бүтээгдэхүүний яг саяын яаралтай үеийн нөөц бол байгаа. Яг олон хүнийг хамарсан гамшгийн үеийн нөөц гэвэл бас тусдаа асуудал болдог. Энэ дээр бол бид нар хадгалалтын хүчин чадал бол яг гамшгийн үеийн нөөцөөрөө тооцоход бол харьцангуй хангалтгүй гэж хэлж болно. Ер нь АХБ-ны эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр 5-ын хүрээнд Цус сэлбэлт судлалын үндэсний төв болон орон нутгийн цусны салбар төвүүдийг бол бүгдийг нь иж бүрэн цус цуглуулах, шинжлэх, хадгалах, тээвэрлэх яг олон улсын стандартад нийцсэн ийм хэрэгслүүдээр бүрэн хангасан байгаа. Тэрнээс гадна тухайн байрлаж байгаа байруудыг нь бол бас стандартын дагуу, яг зөв урсгал чиглэлийн дагууд нь ингэж засварлаж хийсэн. Өөрөөр хэлбэл бас энэ дээр нэлээн бэхжиж чадсан гэдгийг энд хэлэхийг хүсэж байна.

Энэ хичээлийн хөтөлбөр дээр бас өөрчлөлт оруулах асуудал хуулийн төсөл дээр бол явж байсан. Гэхдээ Боловсролын тухай хууль дээр зааж өгснөөр энэ хууль дээр заасан байдлаар зохицуулна гэдэг байдлаар хөтөлбөрийн өөрчлөлтийг зохицуулна гэдэг ийм заалт орчихсон байгаа учраас бас яг энэ дээр бага наснаас нь ирээдүйн тоонуудыг бэлдэх энэ эрүүл мэндийн тухай хичээл дээр гэдэг юм уу оруулах, хөтөлбөр дээр өөрчлөлт оруулах асуудал бол энэ хууль дээр ажлын хэсгийн явцад хасагдсан байгаа.

Залуучуудын цусаа өгөх хандлага бол сүүлийн жилүүдэд маш их нэмэгдэж байгаа. Бид нарын гаргаж байгаа статистик тоо баримтаар аваад үзвэл 10 жилийн өмнөхтэй харьцуулж үзвэл энэ тоо даруй 15-18 хувиар өссөн ийм бас сайн үзүүлэлт бол байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэгт баярлалаа. Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Эрдмийн хөтөч” сургуулийн 12^Г ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе. Удахгүй сургуулиа төгсөөд, хүссэн мэргэжлээрээ, хүссэн сургуульдаа элсэн орж, сайн мэдлэг боловсрол эзэмшэн, эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулсан, хариуцлагатай, эх оронч иргэн болж төлөвшөөрэй. Аав ээжийнхээ, багш нарынхаа үгэнд сайн орж, Монгол Улсынхаа ирээдүйг бас авч явна шүү та хэд маань.

2 гишүүн асуулт асуугаад, дараад нь 1 гишүүн үг хэлээд, түүний дараа зарчмын зөрүүтэй 61 саналаар санал хураалт явагдана. Гишүүдийг танхимдаа бас ирэхийг урьж байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Энэ хуулийг бол хэлэлцэхийг дэмжиж байна. Гэхдээ хэд хэдэн асуулт байна. Энэ 61 саналын томъёоллоор санал хураана гэх юм. Тэгэхээр энэ чинь бараг энэ хууль чинь бүрэн өөрчлөгдөөд орж ирж байгаа юм биш үү. Энэ хууль яасан юм Засгийн газраас өргөн барьсан юм уу, гишүүн өргөн барьсан юм уу. Тэгээд энэ дээр харахад анхдагч хууль ч юм шиг. Гэтэл 2018 онд чинь Монгол Улсын Донорын тухай хуулийг шинэчилсэн найруулгаар баталсан байгаа. Тэгэхээр энэ 2 донорын хууль дээр чинь тэгээд ямар зохицуулалтууд нь үлдэж байгаа юм бэ. Энэ хуулийн будилаанаа жоохон тайлбарлаад өгөхгүй юу гэж хүсэж байна. Тэгээд ер нь Их Хурлын даргад хандаж хэлэхэд 1 хууль орж ирдэг, хам хум санаачилсан болоод, тэгээд 61 саналын томъёолол гэхээр энэ чинь бараг хууль чинь утга санаа нь бүрэн өөрчлөгдчих шиг санагдаж байна.

2 дугаарт энэ хуульд ХДХВ-ийн халдвартай холбогдсон цусны аюулгүй байдалтай холбоотой заалт бас харагдахгүй байна. 2010, 2011 оны үед цусны аюулгүй байдлыг хангах зорилгоор Эрүүл мэндийн яам, Сангийн яамны дэмжлэгтэйгээр 1 тэрбум шахам төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, автомат тоног төхөөрөмжүүд тавьсан санагдаж байна. Одоо тэр төхөөрөмжүүд чинь хэр зэрэг шинэчлэгдсэн бэ. Ажиллаж байгаа юу. Ер нь бол нэг чухал зүйлийг хэлэхэд Монгол Улс бол өнөөдрийг хүртэл энэ цусаар дамжсан ХДХВ-ийн халдвар илрээгүй орны тоонд байгаа. Энэ бол маш чухал үзүүлэлт. Тийм учраас төр засаг энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй. Ингээд энэ цус боловсруулах техник технологийг бид нар байнга орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангаж байх ёстой. Тэгэхээр энэ хууль батлагдсантай холбогдуулаад 2027 оны төсөвт тусгах хөрөнгө оруулалтын заалтуудаа маш хариуцлагатай, эртнээс анхаарч бэлдэж байх хэрэгтэй. Яагаад гэхээр энэ хууль батлагддаг, тоног төхөөрөмжүүд нь төсөв нь батлагдахгүй бол эргээд л энэ хууль бол хэрэгжихгүй. Тэгээд энэ өөрөө их чухал хууль учраас энэ асуудлууд дээр хэр анхаарч байна вэ гэдгийг асууя.

С.Бямбацогт: Энэ хуулийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Жуковын Алдаржавхлан, Аюушийн Ариунзаяа, Нацагдоржийн Батсүмбэрэл нарын 4 гишүүн 2025 оны 3 сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд анх өргөн мэдүүлсэн, анхдагч хууль. Ажлын хэсэг 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн ахлагчаар Баясгалан гишүүн, гишүүдээр Баярбаатар, Энхнасан, Болормаа, Ганмаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат нарын гишүүд ажилласан. Тэгээд ажлын хэсгээс анхдагч хууль 8 бүлэгтэй, нэлээд бас олон зорилттой, заалттай ийм хууль байгаа. Энэ дээр тэгээд бас 62 зарчмын зөрүүтэй санал гарсан юм байна лээ. Мэдээж ажлын хэсэг сайн ажилласан гэсэн үг. Бас өргөн барьсан хуулиудын өөрчлөх ёстой зүйл заалтуудыг, үг үсгийг, утга найруулгыг засах ёстой. Ингээд анхны хэлэлцүүлэг хийгдэж байгаа гэдэг мэдээллийг танд өгье. Тэгээд Ажлын хэсэг нэмж хариулъя. 4 дүгээр микрофон.

Энэ цусны донорын үйл ажиллагаа, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, түүнтэй холбоотой төрийн болон эрүүл мэндийн байгууллагын эрх, чиг үүрэг, цусны донорт болон цус цусан бүтээгдэхүүн сэлбүүлэгчдэд тавигдах шаардлага, түүний эрх, үүрэг, цусны нөөц, хангамж, чанар, аюулгүй байдлыг хангах, цусны донорыг алдаршуулах, урамшуулах, эгнээг нь өргөжүүлэх ажлыг сурталчлах, цус сэлбэлт судлалын салбарт ажиллагсдын нийгмийн баталгааг хангах талаар ийм чухал заалтууд туссан хууль байгаа. Ард иргэдийн бас эрэлт хэрэгцээ нийгмийн

шаардлагад нийцүүлж бас үүнийгээ мэдэрч бас Их Хурлын гишүүд хууль санаачилсан. Ажлын хэсэг нэмж хариулъя. 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Бид нар олон улс дээр бол цус сэлбэлтээр дамжих 4 төрлийн халдварыг бол бүх цуглуулсан цусан дээр үзэхийг зөвлөмж болгодог. Энэ дээр HIV тэгээд В, Ц, гепатит мөн тэмбүүний халдварыг бол 100 хувь үзэж байгаа. Ялангуяа Монгол Улсад маш том тогтолцооны асуудал гарч ирсэн нь 2012 оноос эхлээд бид нар энэ цус сэлбэлтээр дамжих халдварыг PCR буюу нуклейн хүчлийг олшруулах арга гэж одоо яг олон улсын өндөр хөгжилтэй орнуудад хэрэглэж байгаа цусны аюулгүй байдлыг хангахад хамгийн чухал ийм шинжилгээний аргыг нэвтрүүлсэн нь цусны аюулгүй байдлыг хангах, ялангуяа энэ цус сэлбэлтээр дамжих халдварыг бол онцгой бууруулахад чухал ач холбогдолтой болсон. Энэ дээр Эрүүл мэндийн яам, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн зүгээс бол бас нэлээн шат дараатай энэ дээр цусны аюулгүй байдлыг хангахтай холбоотой энэ асуудлуудыг тавьж, 2013 оноос эхлээд 2019 оны хооронд бол АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр энэ тоног төхөөрөмж, аюулгүй байдлыг хангах зүйлүүдийг бол бас бүгдийг нь шийдвэрлэж өгснөөрөө бас онцлог болсон. Тэрнээс гадна энд шаардлагатай урсгал зардлуудыг бол тухайн жилийн төсөв дээр нь тусгаж өгснөөр энэ бас олон улсын зөвлөмжүүд дээр хүрсэн.

Цус сэлбэлтээр дамжих халдварын хасагдалтын хувь бол тухайлбал 2019 онд 100 хүнээс 3,6 хувь байсан бол өнөөдрийн 2025 оны байдлаар 1,4 хувь болчихсон байгаад байгаа юм. Гэхдээ энэ дээр нэлээн дийлэнх эзлэх хувь дээр в,ц-ийн халдварын эрсдэлүүд бас нэлээн өндөр байдаг. Өөрөөр хэлбэл цус сэлбэлтээр авсан цуснаас шинжилгээ хийж үзэхэд бол энэ халдвартай хүмүүс бас нэлээн өндөр хувийг энэ халдвар дотроо эзэлж байгаа. Яг таны хэлснээр ямар нэгэн байдлаар HIV-ийн халдвар авсан хүн бол цус сэлбэгдээгүй гэдэг ийм томъёоллоор бид нар бас энэ ДЭМБ дээр өгч байгаа тайлан мэдээнүүд дээр орж явж байгаа

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Жадамбаагийн Баясгалан гишүүн нэмж хариулъя.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Одонтуяа гишүүнийхээ асуултад хариулъя. Энэ бол маш чухал асуулт байлаа. Бид нар Донорын тухай хуультай. Донорын тухай хуулиа илүү нарийвчилж, илүү ажиллахын тулд эд, эрхтэн, эс шилжүүлэх гэж тусдаа, нөгөөдөх нь Цусны донорын хууль гэж ингэж 2 тусдаа болж байгаа. Энэ 2 хууль маань батлагдсанаараа Донорын тухай хууль маань өөрөө хүчингүй болно. Ингээд зөрчилдөх зүйл байхгүй болно. Харин энэ дээр нарийвчлалтайгаар бусад бид нарын энэ ажлын хэсэг энэ 61, 62 санал оруулж ирж байгаа. Энэ бүх зүйл дээр нь өөрчлөлт хийж, бүгд дээр нь санал авч, 18 удаа нийт ажлын хэсэг хуралдсан. Ингээд 18 удаагийн ажлын хэсгийн хуралдаанаар энийгээ шийдээд, тэгээд ингээд өнөөдөр энэ асуудал орж ирж байгаа.

С.Бямбацогт: Одонтуяа гишүүн тодруулж асууя.

С.Одонтуяа: Тодруулж асуулт байхгүй. Тодруулж бас 1 зүйлийг хэлье. Ажлын хэсэг бол сайн ажилласан байна. Үнэхээр бас энэ хууль бүх зүйл нь алдаа мадаггүй байхад бол ажлын хэсгийн үүрэг бас чухал байдаг. Зүгээр би ямар санаагаар хэлсэн бэ гэхээр манай гишүүд болон Засгийн газар хууль санаачлаад орж ирэхдээ угаасаа

л энэ яам, дэд хэсэг энэ бүх хүмүүс чинь хэдхэн л мэргэжлийн л хүмүүс байдаг. Энэ байгууллагын хүмүүстэй хамтарч ажиллаад, хуулиа оруулж ирэхдээ эхнээс нь бас жоохон чанартай оруулж ирж байх л гэсэн ийм санааг хэлсэн. Тэгээд ажлын хэсэг бол сайн ажиллаад, алдаа мадаггүй бүх юмыг нь засаад энэ хууль батлагдаж байгааг бол дэмжиж байгаа.

С.Бямбацогт: Буланы Бейсен гишүүн асуултаа асууя. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Үүний дараа санал хураалт явагдана.

Б.Бейсен: Хуулийн төслийг дэмжиж байна л даа. Тэгэхдээ 1 асуудал байна. Энэ чинь хуучин байсан хууль байхгүй юу. Цусны донорын тухай байсан шүү дээ. Жил болгон эмнэлгүүдийн магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтэд орсон юм. Тэгэхээр чинь зарим юм хүчингүй болно гээд энийг тэгэхээр ажлын хэсгийнхэн, яамныхан онцгой анхаарахгүй бол салгаад тусдаа болгочихоор чинь цусны тухай асуудал дээр бас юм гарчих вий 1 дүгээрт.

2 дахь асуудал хөдөө аймгуудын цусны салбар станцуудын аппарат, тоног төхөөрөмж хэр хангалттай байна. Цус хадгалах сав, хөргөгч, тэгээд хөлдөөгч, Эритроцитын масс, Тромбоцитын масс, сийвэн тэгээд Лейкоцитын масс, Криопреципитат ялгах аппаратуудаар хангагдсан уу.

Би Эрдэнэбаяр даргад бас баярлаж байгаа. Хуучин Цусны төвийн дарга байхдаа Баян-Өлгий аймаг хамгийн алслагдсан аймгийг цусны орчин үеийн тоног төхөөрөмж аппаратаар хангасан. Одоо ажиллаж байгаа. Өчигдөр гэхэд энэ өнөөдөр 6 хонож байна уу, 7 хонож байна уу, 1 эх цус алдсан. Аймаг даяар цус өгөх хүнийг цуглуулсан. 4 дүгээр бүлгийн цус байхгүй асуудал гарсан. Одоо яаманд авч ирэх гэхээр тээвэрлэх боломжгүй. Наашаа хүрэхгүй бол бас үрээтэр нь гэмтсэн тийм хүнд хүн дээр цусны асуудал гарсан л даа. Бараг 3,6 литр цус, 10 литр цус, цусан бүтээгдэхүүн хийсэн Криопреципитат, сийвэнтэйгээ нийлээд. Эхийн эндэгдэл гарчих вий. Энэ дээр яамныхан бас анхаарах шаардлагатай байна.

2 дахь асуудал энэ эх барих болон гэмтлийн юунд гарцаагүй цус сэлбэх асуудал байж байгаа. Би цус алдалттай хүнд олон хагалгаанд орж байсан. Ялангуяа эх барихын эмч нар хөдөө сум, баг, айл өрхийн түвшинд хагалгаа орж байгаа юм. Сетра-аа аваачаад тэнд яах вэ, В, Ц вирус үзээд л шинжилгээгүй шууд хагалгаанд орж байгаа. Бүлгийн тодорхойлж байгаад орж байгаа асуудал байгаа. Тэгэхээр юу гэвэл энэ дээр сайн тусгахгүй бол аймгийн хэмжээний БЗХӨ, цусны өвчин, элэгний архаг өвчин, В, Ц вирус, Д вирусийг ялгаж байж эрүүл хүний тооцоог нь ер нь улс даяар гаргасан уу. Эрүүл мэндийн салбар 100 жил болоход. Энийг гаргахгүй бол өчигдөр тэр цус алдалттай хүн дээр чинь бараг аймаг даяар фэйсбүүкээр цуурлаа шүү дээ. Ялангуяа В, Ц вирусийг энэ цус сэлбэх төвүүд дээр найдвартай үзэж чадаж байна уу. Дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон. Ажлын хэсэг хариулъя.

Н.Эрдэнэбаяр: Бейсен гишүүний асуултад хариулъя. Эрүүл мэндийн яам Эрдэнэбаяр. Хууль бол одоо Донорын тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тухай хууль, Цусны донорын тухай хууль гэж ингэж 2 хууль болж салж хуульчлагдаад явна. Тэгэхээр энэ дунд ямар нэг

байдлаар завсрын хугацаа байхгүйгээр 1 дор ингээд явна гэдэг байдлаар 2 ажлын хэсэг бол хоорондоо бас ярилцаж явж байгаа.

Эх барихын цус алдалтын асуудлууд дээр бас Эрүүл мэндийн яам, Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс бас энэ мэдээллүүд бол байгаа. Ялангуяа Баян-Өлгий аймаг дээр саяын гарсан энэ хүндрэлтэй холбоотой Улаанбаатар хотоос 20 нэгж улаан эсийн бүтээгдэхүүнийг бас онгоцоор тээвэрлэж, Баян-Өлгий аймагт хүргүүлсэн байж байгаа. Тэгээд энэ дээр бас арга хэмжээ авч, Улаанбаатар хотод татаж авахаар бид нар бас тухайн нэгдсэн эмнэлгийн хүмүүстэйгээ ингээд ярилцаад, ажиллаж байна. Яг одоо малчны хотонд гэдэг юм уу, хөдөө хээр газар үнэхээр амин шаардлагатай биш бол бид нар цус сэлбэлтийг бол хориглодог байж байгаа. Яг үнэхээр амь насны заалтаар цус сэлбэлт явагдаж байгаа үед 1 дүгээрт нь бид нар боломжтой бол тэр үнэлгээ хийгээд, шаардлагатай цус, цусан бүтээгдэхүүнийг өөрөөр хэлбэл 100 хувь ингээд аюулгүй байдлыг хангачихсан цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэж, сэлбэдэг байгаа.

Нөгөө талаас нь бол яадаг вэ гэхээр үнэхээр нэмэлтээр шаардлагатай байгаад байгаа бол өмнө нь бүртгэлтэй байгаа доноруудаас буюу байнга цусаа өгдөг доноруудаас сонгож авдаг. Тэгэхээс яг анх удаа цусаа өгч байгаа хүнээс бол энийг бол авдаггүй. Өөрөөр хэлбэл энэ бас цусны аюулгүй байдлыг хангахад онцгой нөлөөтэй гэдэг ийм бас зохицуулалт байгаа.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Буланы Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Тэгэхээр энэ резус нэмэх, хасахыг яаж үзэж байна. 1 дүгээрт.

2 дугаарт сая зарим юм чинь хөдөө авч явах боломжгүй задарчихдаг асуудлууд байж байна. Хөдөө цус хийхдээ жишээлбэл шинэ хөлдөөсөн сийвэнд л авч явж байна. Бусад юунуудыг авч явах боломжгүй болчихоод байна. Тэгэхээр энэ сум, багийн түвшинд ийм хагалгаа ороход аймгийн нэгдсэн эмнэлгийн эх барихын эмэгтэйчүүдийнхэнтэй очоод орж байгаа л даа. Заримдаа хүний амь нас алдсан ч тохиолдлууд гардаг. Элэг задарсан гарцаагүй тохиолдлууд байдаг. Тэгэхээр энэ үед тэр цусны төвүүдийн чадавхыг сайжруулахын тулд ер нь ямар арга барилыг/минут дуусав/

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. 4 дүгээр микрофон.

Н.Эрдэнэбаяр: Бейсен гишүүний асуултад нэмэлтээр хариулъя. Энэ цусаа өгч байгаа донорууд дээр бид нар А, Б, О бүлгээс гадна резус бүлгийг заавал үзэж байж яг тохирох цусыг сонгодог байж байгаа. Энэ бол 100 хувь үзэж байгаа. Ер нь бид нар Цус сэлбэлт судлалын үндэсний төв дээр цусны жижиг бүлгүүд буюу нийт 365 бүлэг ер нь байдаг. Цусны бүлэг. Үүнээс эмнэл зүйн ач холбогдолтой 10 орчим бүлгийг бас нарийн үзэж байж жишээ нь элэг шилжүүлэн суулгах мэс засал гэдэг юм уу ийм нарийн технологи шингэсэн хагалгааны үеийн бас цус, цусан бүтээгдэхүүнийг бэлтгэж ингэж олгодог байгаа.

Орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийг сургаж бэлтгэх асуудал, хүний нөөцийг сургаж бэлтгэх энэ тасралтгүй байдлыг хангах гэдэг бол бас их чухал байгаад

байгаа. Энэ дээр бас байнгын сургалт семинарыг бас зохион байгуулж, энэ дээрээ бас жил болгон үйл ажиллагаануудыг нь бас үнэлэлт дүгнэлт өгч ажилладаг байгаа.

Тоног төхөөрөмжийн хувьд түрүүн бас та асуусан. Энэ дээр бол тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгээд 10 жил .../минут дуусав/

С.Бямбацогт: Бейсен гишүүн тодруулж асууя.

Б.Бейсен: Би дахиад хэлье. Цус, цусан бүтээгдэхүүн авах тухай урьд нь хууль байсан. Донорын хууль бол анхдагч хууль гээд ярьж болно. Донорын тухай ч тэр юун дотор байсан хууль байхгүй юу. Энэ хуульд өөрчлөлт гээд оруулахгүй бол дахиж шинээр хууль гаргасан мэт ерөөсөө болохгүй. Хуулийн өөрчлөлтийг ингээд салбарынхан зарим нь сайд байсан хүмүүс анхдагч хууль гээд ярьж ерөөсөө болохгүй.

С.Бямбацогт: Үг хэлчихсэн үү. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн болон эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно. Аюушийн Ариунзаяа гишүүн үг хэлэх юм байна. Санал хурааж эхлэхээр үг хэлэх ёстой тийм үү. Зарчмын зөрүүтэй 62 санал байгаа. Бүгдийг нь хураана. Энэ чухал хууль учраас бас хэдүүлээ идэвхтэй оролцоод баталчихъя. Гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Гишүүдийн зөвлөх, туслахууд өрөөндөө ажиллаж байгаа гишүүдийг чуулганы танхимд хурдан ирүүлнэ үү. Гишүүдийн зөвлөх, туслахууд чинь бас үүрэгтэй шүү дээ. Гишүүний ажлыг нь хийлгэх, ажиллах ажил нөхцөл бололцоог нь хангах, бүлгийн дарга нар, бүлгийн дэд дарга нар Улсын Их Хурлын Хуралдаан зохион байгуулах газар, бүлгийн ажлын алба бас гишүүдийг чуулганы танхимдаа бас хүрэлцэн ирэх нөхцөл бололцоог нь бүрдүүлээрэй.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийн урилгаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын удирдлага болон орон нутгийн төрийн өмчийн газрын мэргэжилтнүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн төрийн болоод төрийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан эдгээр төлөөлөгч, төрийн албан хаагчид маань өчигдөр бас төрийн болон орон нутгийн өмчийн компанийг бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцсон. Өнөөдөр Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байгаа юм байна. Төрийн албан хаагч байна гэдэг бол ард түмнийхээ өмнө хүлээсэн үүрэг, хариуцлага, нэр төр юм шүү гэдгийг бас үргэлж санаж, улс орныхоо маргаашийн хөгжлийн төлөө идэвхтэй ажилладаг та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе.

Засгийн газраас Нийтийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн засаглал, ил тод байдал, бүтээмж, хариуцлагыг нэмэгдүүлэх тухай хуулийг Их Хуралд өргөн барьсан. Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа гишүүн ахалж байгаа. Номинчимэг гишүүн, Сайнзориг нар дэд ажлын хэсгийг бас ахалж ажиллаж байгаа. Бас манай гишүүд маань маш идэвхтэй ажиллаж, энэ хуулиудыг энэ хаврын чуулганд хэлэлцэн баталж, та бүгдийн бас ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, илүү ойлгомжтой, тодорхой болгох, төрийн өмчит компаниудын талаар

ард иргэдийн дунд шүүмжлэгдээд байдаг шүүмжлэлүүдийг арилгах, засах, залруулах, төрийн өмчит компанийн үр ашгийг улам нэмэгдүүлэх, томоохон хуулиудыг анхдагч хуулиудыг Улсын Их Хурал хэлэлцэж байгаа. Энэ бол маш чухал ач холбогдолтой хууль. Тэгээд энэ хуулийг батлуулахаар ажлын хэсэгт ажиллаж байгаа нийт гишүүддээ бас нийт Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс баяр хүргэе. Сайн ажиллаж байгаа шүү гэдгийг цохон тэмдэглэж хэлье.

Номинчимэг гишүүн ажлаа сайн хийж байгаа шүү гэж манай Даваагийн Цогтбаатар гишүүн уламжлаарай гэж байна.

Санал хураалтдаа бэлдье гишүүд. 36 гишүүн бэлэн болсон байх юм. Танхимд 52 гишүүн байна. Санал хураалтдаа бэлтгэж амжаагүй гишүүд санал хураалтдаа бэлдье. Чуулган танхимд ирээгүй байгаа гишүүд танхимдаа хүрэлцэн ирье. Гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ танхим руу яаралтай явуулна уу. Өрөөндөө ажлаа хийж байгаа байх. Танхимд 54 гишүүн байна. Ирцдээ 48 гишүүн бэлэн болсон байна. Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд, бүлгийн дарга, дэд дарга нар ирээгүй гишүүдийг танхимд хүрэлцэн ирүүлэе. Бүртгэлийн санал хураалт. Ирцийн санал хураалт. Ирцдээ ороогүй гишүүд ирцдээ орчихъё. Нэлээн хэдэн гишүүн манай Жангабыл гишүүн, Наранбаяр гишүүн өшөө хэн хэн ороогүй байна. Хуруугаа уншуулаад. Энэ 55 гишүүнээс ер нь ирцдээ орчхоод гараад явчихсан гишүүд гэсэн үг шүү. Пүрэвдорж гишүүн ирцдээ ороогүй байна. Тэнд эсрэг гараад байна. Эрдэнэбүрэн гишүүн ирцдээ ороогүй байна та бас. Ундраа гишүүн суучихъя. Ирцээ уншуулаарай гишүүд ээ. Бүртгэлийн санал хураалт. 58 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 44 гишүүн ирцдээ орчхоод, санал хураалтад ирээгүй байна. Энэ 44 гишүүнийг чуулгын танхимд урьж байна. Тэгээд өглөө ирцдээ орчхоод, санал хураалт болохоор ингээд алга болчихдог байж таарахгүй. Энэ татгалзсан гэж гарч байгаа 44 гишүүн бол ажлаа хийхгүй байна гэсэн үг шүү. Тийм дэг байхгүй. Санал хураалтууд явуулъя.

Цусны донорын тухай хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёолол:

Нэг.Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороо дэмжсэн санал

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилгоор сайн дураар цусаа үнэ төлбөргүй өгөх болон цусны донорын үйл ажиллагаа, цусны аюулгүй байдал, бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баясгалан, Баярбаатар, Энхнасан, Болормаа, Рэгдэл, Отгонбаяр, Сарнай, Эрдэнэбат цаашид “ажлын хэсэг” гэж нэрлэнэ. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 102 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 57,8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ, Олон улсын гэрээний тухай хууль” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн ахлагчид микрофон өгье. Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Баярлалаа. Энэ санал хураалтаас өмнө Байнгын хороо дээр гишүүдийн гаргасан саналтай холбогдуулаад 2, 45, 46, 55 дугаар саналууд дээр гүйцээн боловсруулах чиглэл авах гэсэн юм.

С.Бямбацогт: Ажлын хэсэг гүйцээн боловсруулах чиглэл авах санал гаргасан учраас гүйцээн боловсруулах чиглэл өгөөд энэ санал хураалтыг хойшлууллаа.

3.Төсөл доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмэх:

“3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амийг аврах зорилтын хүрээнд цусны донорын үйл ажиллагааг зохион байгуулах, цусны аюулгүй байдлыг хангах, цус сэлбэлт судлалын салбарын бодлого, удирдлага, зохион байгуулалттай холбогдсон харилцааг зохицуулна.

3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд заасан тохиолдолд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэнд, амийг аврах зорилгоор цус сэлбэх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 103 гишүүн оролцсоноос 64 гишүүн буюу 62,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийн урилгаар Орон нутгийн төрийн өмчит газрын газрын мэргэжилтнүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхнийхээ төрийн өмчийг хамгаалах, хадгалах, өсгөх, үржүүлэх, арвижуулах энэ хариуцлагатай ажилд нь амжилт хүсье. Улсын Их Хурал дээр бас Нийтийн өмчийн болон төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдал, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Үүрийнтуяа, Сайнзориг, Номинчимэг нарын гишүүд ажлын хэсэг гарч ажиллаж байгаа. Удахгүй Улсын Их Хурал энэ хуулийг батална. Ингэснээр илүү та бүхний ажиллах эрх зүйн орчин, нөхцөл байдал сайжирна. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс өргөн барья.

4.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтын “цус” гэснийг “цус, цусны бүрэлдэхүүн хэсэг” гэж, мөн заалтын “аюулгүй байдлыг хангахтай” гэснийг “аюулгүй байдал, сонор сэрэмжийн тогтолцоотой” гэж өөрчилж, мөн зүйлийн 3.1.2 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 103 гишүүн оролцсоноос 63 гишүүний 61,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.4 дэх заалт нэмэх:

“3.1.4.“цусны байнгын донор” гэж жилд тогтмол 2 ба түүнээс дээш удаа цусаа өгсөн хүнийг;” Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 103 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 58,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “амь нас, эрүүл мэндээ хамгаалах зорилгоор” гэснийг, мөн зүйлийн 3.1.8 дахь заалтыг тус тус хасах. Санал

гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 62 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11-д заалтын “биобэлдмэл” гэснийг “бэлдмэл” гэж, мөн заалтын “цус, цусны бүрэлдэхүүн хэсгээс” гэснийг “цусны сийвэнгээс” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 3.1.10 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 61 гишүүн буюу 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 3.1.12 дахь заалт нэмэх:

“3.1.12.“Цусны сонор сэрэмжийн тогтолцоо” гэж “цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг авах, цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх явцад гарах сөрөг урвал, хүндрэлийг илрүүлэх, шуурхай арга хэмжээ авах, сэргийлэх цогц үйл ажиллагааг.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 61 гишүүн буюу 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж ш, мөн зүйлийн 4.1.6 дахь заалтыг хасах:

“4.1.3-д чанар, аюулгүй байдлыг хангах;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 61 гишүүн буюу 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Төслийн 2 дугаар бүлгийн нэрийн “ТОГТОЛЦОО” гэснийг “УДИРДЛАГА, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ” гэж өөрчилж, төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдал, цусны донорын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сантай холбоотой төрийн хяналтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төрийн байгууллага хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 63 гишүүн буюу 61,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “, цусны биобэлдмэлийн үйлдвэрлэл эрхлэх” гэснийг хасаж, мөн хэсгийн “эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу” гэж өөрчилж, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103-аас 62 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

13.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг нь “гамшгийн” гэсний дараа “болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.5.“Цусны хүндэт донор” цол тэмдгээр шагнах;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 61 гишүүн 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “төрийн бодлогыг Улсын Их Хурлаар батлуулах,” гэснийг “бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн” гэж, мөн зүйлийн 6.1.3 дахь заалтын “санхүүжилтийг” гэснийг “түүнтэй холбогдон гарах санхүүжилтийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 61 гишүүн буюу 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

14 төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтыг “хэмжээг” гэснийг “албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг” гэж өөрчилж, мөн заалтын “, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх” гэснийг мөн зүйлийн 6.1.7 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 63 гишүүн буюу 61,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15.Төслийн 7 дугаар зүйлийг бүхэлд нь хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 65 гишүүн буюу 63.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

16.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “үйл ажиллагааг зохицуулах” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.1.2.цусны донорын үйл ажиллагааны талаар баримтлах бодлого боловсруулах, удирдлага, зохион байгуулалтаар хангах;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 64 гишүүн буюу 62,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын “батлах” гэснийг “баталж, хэрэгжилтэд хяналт тавих” гэж, мөн зүйлийн 8.1.5 дахь заалтын “орц, илчлэгийн жишиг” гэснийг “зардлын” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 8.1.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 62 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

18.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын “нэмэгдэл цалингийн хэмжээ,” гэснийг “цалин, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл,” гэж, мөн заалтын “санал боловсруулах” гэснийг “талаар санал боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 63 гишүүн буюу 61,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

19.Төслийн Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг 8.1.7, 8.1.8 дахь заалт болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.7.цус сэлбэлт судлалын салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх;

8.1.8.цусны донорын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх болон өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэндийг дэмжих санд

тусгах;" Санал гаргасан ажлын хэсэг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 66 гишүүн буюу 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

20.Төслийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2 дахь хэсэг нэмэх:

"8.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллагын бүтэц, дүрмийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 64 гишүүн буюу 62,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

21.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "хуулийн 15.1.12-т" гэснийг "хуульд" гэж өөрчилж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 67 гишүүн буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

22.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтын "цусны чанар, аюулгүй байдал, цус, цусан бүтээгдэхүүн, зохистой хэрэглээ, цусны сонор сэрэмжийн тогтолцоо" гэснийг, мөн заалтын "удирдлага, зохион байгуулалт" гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 66 гишүүн буюу 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

23.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын "сурталчилгааны ажлыг" гэснийг "сурталчилгаа, донорын эгнээг өргөжүүлэх ажлыг" гэж өөрчилж, мөн заалтын "цусны донор элсүүлэх" гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 67 гишүүн буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

24.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.5 дахь заалтын "Биобэлдмэл" гэснийг "бэлдмэл" гэж, мөн зүйлийн 9.3.7 дахь заалтын "талаарх магадалгаа" гэснийг "тухай тодорхойлолт" гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 9.3.8 дахь заалтын "байгууллага" гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 67 гишүүн буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

25.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.9 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

"9.3.9 энэ хуулийн 20.1-д заасан донорыг Засгийн газрын шагнал болон бусад шагналд нэр дэвшүүлэх саналаа холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх;" Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүний 69 гишүүн буюу 67 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

26.Төслийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.3.10 дахь заалт нэмэх:

"9.3.10.цусны байнгын донорт тэмдэг олгох;" Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 67 гишүүн буюу 65 саналаар энэ санал дэмжигдлээ.

27.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.10 дахь заалтын "бүрдүүлэлт, өөрчлөлт, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцах талаар хууль тогтоомжоор тогтоосон үүргийг хэрэгжүүлэх" гэснийг "аюулгүй байдлын талаар холбогдох хууль

тогтоомжийн хэрэгжилтийг хангах” гэж өөрчилж, мөн зүйлийн 9.3.11 дэх заалтын “улсын хэмжээнд нэгтгэх” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 66 гишүүн 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

28.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 65 гишүүн 63,1 хувийн саналын санал дэмжигдлээ.

29.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.4.Цус сэлбэл судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлд шаардагдах төсвийн зардлаа жил бүр улсын төсөвт тусгуулахаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.5.Цус сэлбэлт судлалын асуудлыг хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь дараах байгууллагатай хамтран ажиллана:

- 9.5.1.эрүүл мэндийн байгууллага;
- 9.5.2.төрийн болон төрийн бус байгууллага;
- 9.5.3.аж ахуйн нэгж, байгууллага.

9.6.Хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 68 буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

30.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.2, 15.1.3, 15.1.5, 15.1.6, 15.1.7, 15.1.11, 15.1.13-т заасан эрүүл мэндийн байгууллага цусны донорын үйл ажиллагаанд оролцоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 62 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

31.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг бүхэлд нь доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.2.Энэ хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн байгууллага нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд цусны донорын үйл ажиллагаа, цусны чанар, аюулгүй байдлыг хангах, журам, стандарт, зааврыг хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 66 гишүүн буюу 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

32.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “донор элсүүлэх” гэснийг хасаж, мөн заалтын “тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх” гэснийг “цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд” гэж өөрчлөх. Санал гаргасан

ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 68 гишүүн бий 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

33.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.2.гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, нөхөн сэлбэхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх, удирдлага зохион байгуулалтаар хангах.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 68 гишүүн буюу 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

34.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 66 гишүүн буюу 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

35.Төслийн 12 дугаар зүйлийн гарчгийн “Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан, ажил олгогчийн эрх, үүрэг” гэснийг “Цусны донорын үйл ажиллагаанд оролцох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 64 гишүүн буюу 62,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

36.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “байгууллагын албан тушаалтан ажил олгогч нь” гэснийг “болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж” гэж, мөн зүйлийн 12.1.3 дахь заалтын “магадалгааг” гэснийг “тодорхойлолтыг” хийж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 67 гишүүн буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

37.Төслийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.1.4 дэх заалт нэмэх:

“12.1.4.цусны донорын үйл ажиллагааны талаар нийгэмд чиглэсэн ашгийн бус сурталчилгаа явуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 62 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

38.Төслийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 64 гишүүн буюу 62,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

39.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “эрүүл мэндийн даатгал” гэснийг хасаж, “хамт олон, иргэн,” гэсний дараа “олон улсын байгууллагын” гэж нэмж, төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.2.Цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан эрүүл мэндийн байгууллага нь өөрийн орлого, аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдсэн санхүүжилтийн эрүүл

мэндийн тухай хуулийн 24.5-д заасны дагуу зарцуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 66 гишүүн буюу 64.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

40.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх хэсгийг бүхэлд нь тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 65 гишүүн буюу 63,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

41.Төслийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.6.Цус сэлбэлт судлалын салбарт ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтанд Төрийн албаны тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуульд заасан нэмэгдлээс гадна албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 68 гишүүн буюу 66 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

42.Төслийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийн “Цусны албаны нэмэгдэл цалингийн хэмжээг” гэснийг “Энэ хуулийн 13.6-д заасан нэмэгдэл олгох журмыг эрүүл мэндийн болон” гэж, мөн хэсгийг “тогтооно” гэснийг “батална” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 67 гишүүн буюу 65 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

43.Төслийн Гуравдугаар зүйлийн гарчгийн “СЭЛБҮҮЛЭГЧ” гэснийг хасаж, төслийн 14, 17 дугаар зүйлийг нэгтгэн 14 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“14 дүгээр зүйл.Цусны донорт тавигдах шаардлага, түүний эрх, үүрэг

14.1.Цусны донор дараах шаардлагыг хангасан байна:

14.1.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ сайн дураар, авлагагүйгээр өгөхийг зөвшөөрсөн байх;

14.1.2.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байх;

14.1.3.эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

14.2.Цусны донор дараах эрхтэй:

14.2.1.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөнтэй холбоотой гарч болзошгүй сөрөг урвалын талаар мэдээлэл, зөвлөгөө авах;

14.2.2.цусны донорын үйлсийг сурталчлах, эгнээг өргөжүүлэх ажилд сайн дураар оролцох;

14.2.3 Хуульд заасан бусад.

14.3.Цусны донор дараах үүрэгтэй:

14.3.1.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 18.2.7-д заасан мэдээллийг холбогдох эмнэлгийн мэргэжилтэнд үзүүлэх;1

14.3.2.өөрийн эрүүл мэндийн байдлыг асуумжийн дагуу үнэн зөв мэдээлэх;

14.3.3.цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгөхийн өмнөх үзлэг, шинжилгээнд хамрагдах;

14.3.4.эмнэлгийн мэргэжилтний өгсөн зөвлөмжийг мөрдөх;

14.3.5.хуульд заасан бусад.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 67 гишүүн буюу 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

44.Төслийн 15, 16, 18 дугаар зүйлийг нэгтгэн 15 дугаар зүйл болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг

15.1.Иргэний амийг аврах, эрүүл мэндийг сайжруулах зорилгоор цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэхдээ сэлбүүлэгч эрх зүйн бүрэн чадамжтай бол өөрөөс нь, хүүхэд болон эрх зүйн бүрэн чадамжгүй сэлбүүлэгчийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс бичгээр зөвшөөрөл авсан байна.

15.2.Энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авахдаа цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх шаардлага, сэлбэх явцад гарах үр дагаврын талаар сэлбүүлэгчид урьдчилан танилцуулсан байна.

15.3.Амь тэнссэн үед, эсхүл энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг авах боломжгүй тохиолдолд холбогдох журам, зааврыг баримтлан цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэнэ.

15.4.Цусны донорын үйл ажиллагаанд оролцогч эмнэлгийн мэргэжилтэн Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

15.5.Хуульд заасан бусад” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүн 63 гишүүн буюу 61,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

45, 46 дугаар саналууд дээр гүйцээн боловсруулах чиглэл авах юм байна. Ариунзаяа гишүүн үг хэлье.

А.Ариунзаяа: Хууль санаачлагчийн хувьд ажлын хэсэг бас сайн ажилласанд талархлаа дэвшүүлж байна. Энэ хуулийн 21, 22 зэрэг дараагийн 3 бүлгийг нэгтгэх ийм санал гаргасан. Тэгээд энэ явцдаа бас чухал 1 заалтыг хассан нь яг нийтийн тээврээр нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/ орон нутгийн харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих гэсэн ийм заалт байсан. Тэгээд одоо бол яг Хүндэт донорууд нийслэлд нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчдог. Мөн картаа уншуулахад Хүндэт донор гэдэг нэрээр нь бас уншиж, өгдөг ийм журамтай явж байгаа. Тэгээд үүнийг хуульчилж өгсөн нь бол

цааш цаашдаа ер нь аймаг, орон нутгийн Хүндэт донор байсан ч гэсэн Улаанбаатар хотод харьяалал харгалзахгүйгээр нийтийн тээврээр зорчих ийм заалт байгааг хэвээр үлдээх ийм санал гаргаад, Байнгын хороо дээрээ дэмжигдээд явсан. Хүндэт донор 35 ба түүнээс дээш удаа цус, цусан бүтээгдэхүүний хэсгээ бэлэглэсэн хүмүүсийг алдаршуулдаг.

1963 оноос хойш Монголд 2990 гаруй Хүндэт донор бий болсон. Өнөөдөр яг идэвхтэй цусаа өгч байгаа 1400 орчим Хүндэт донор байгаа юм. Тэгэхээр эдгээр Хүндэт донорыг нийтийн тээврээр үнэ төлбөргүй 1 дүгээрт зорчуулах, 2 дугаарт хүндэт донор гэж алдаршуулж байгаа нь өөрөө 1 талдаа өдөр болгон бид бас талархлаа илэрхийлж байгаа ийм явдал мөн юм. Тэгэхээр хүн ер нь энэ эрэгтэй хүн 2 сар тутамдаа 1 удаа, эмэгтэй хүн 3 сар тутамд 1 удаа цусаа өгч болдог. Тэгээд ер нь таны 1 удаагийн өгсөн цус чинь 3 хүнийг аварна гэж бид нар ярьдаг. Гэхдээ яг цагаа тулах юм бол 3 хүний байтугай, 30 хүний цус ч гэсэн 1 хүний амийг аврахад бас багаддаг ийм тохиолдол байдаг юм. Ийм учраас аль болох уг нь яг энэ цус, цусан бүтээгдэхүүний талаар цусаа өгч байх ач холбогдлын талаар бид нар илүү сайн хүмүүст ярьж байх ёстой юм гэдгийг онцолж, сургалтын хөтөлбөрт бас оруулбал яасан юм бэ гэсэн ийм санал гаргасан. Гэхдээ энэ санал яг хуулиас хасах ийм саналыг ажлын хэсэг гаргасан байна лээ.

Ер нь цусаа өгсний дараа сийвэн 24 цагийн дотор, улаан эс 4-6 7 хоногийн дотор бүрэн нөхөгддөг. Энэ үед бол цусны шинэ эсүүд эрчимтэй төлжиж эхэлдэг. Тэгэхээр тогтмол цусаа өгөх нь бие дэх төмрийн илүүдлийг бас тэнцвэржүүлж, зүрх судасны өвчлөл, цус харвалт болон хорт хавдар тусах эрсдэлийг үлэмж хэмжээгээр бас бууруулдаг юм. Нэн ялангуяа Ковидын дараах энэ цаг үед маш олон залуучууд цус өтгөн байгаа учраас хэрхэн яаж сэргийлэх вэ гэж бодож байгаа бол цусаа өгөх нь 1 талдаа бас буян болохоос гадна таны эрүүл мэндэд ач тустай юм байна шүү гэдгийг та бүхэндээ бас энэ ташрамд бас хэлмээр байна. Ингээд цусаа өгөхийг уриалж байна.

С.Бямбацогт: Ариунзаяа гишүүнд баярлалаа. Санал хэлсэн.

45, 46 дугаар саналуудыг Байнгын хороо, ажлын хэсэгт гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

47.Төслийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсгийн “гүйцэтгэж болно.” гэснийг “гүйцэтгэнэ.” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.4, 22.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 56,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Гишүүд бас анхааралтай байж саналаа өгцгөөе.

48.Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “зүйлийн 22.5 дахь хэсэгт заасан” гэснийг “хуулийн 10.1-д заасан эрүүл мэндийн” гэж, тус заалтын “цус сэлбэлт судлалын асуудал хариуцсан” гэсний дараах “тусгай мэргэжлийн төвд” гэснийг “эрүүл мэндийн байгууллагад” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 58 гишүүн буюу 56,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

49.Төслийн 22 дугаар зүйлийн 22.7, 22.8 дахь хэсгийг нэгтгэн 22.7 дахь хэсэг болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.7.Цус, цусан бүтээгдэхүүнийг Эрүүл мэндийн тухай хуулийн 37.3-т заасан журмын дагуу эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж болно.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 61 гишүүн буюу 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

50.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсгийн “биобэлдмэлийг” гэснийг “цусны бэлдмэлийг” гэж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “байдлын хувьд баталгаажсан” гэснийг “байдлыг хангасан” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 63 гишүүн буюу 61,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

51.Төслийн 24 дүгээр зүйлийн гарчгийн “онцгой” гэснийг “ноцтой” гэж өөрчилж, мөн зүйлийн 24.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед цус, цусны бүрэлдэхүүн хэсгийг цуглуулах ажлыг улсын хэмжээнд гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын алба, тодорхой нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед орон нутгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу зохион байгуулна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 61 гишүүн буюу 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

52.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.2, 24.3, 24.4, 24.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 62 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

53.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсгийн “24.1, 24.3, 24.5-д заасантай” гэснийг “24.1-д заасан зохион байгуулалттай” гэж, мөн хэсгийн “холбоотой зардлыг” гэсний дараах “Засгийн газрын нөөц сангаас” гэснийг “Гамшгийн тухай хуулийн 51.4-т заасны дагуу” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 60 гишүүн буюу 58,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

54.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийн “сангийн” гэснийг “сан байгуулах, ажиллах” гэж өөрчилж, мөн хэсгийн “эрүүл мэндийн” гэсний дараах “асуудал эрхэлсэн” гэснийг хасах:

“25.1.Цусны донорын үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих зорилгоор цусны донорын мэдээллийн сантай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүн 62 гишүүн буюу 60,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

55.Төслийн 25 дугаар зүйлийн 25.3, 25.4, 25.5 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Учлаарай энэ санал хураалтыг хүчингүй болгоё. 55 дугаар саналыг гүйцээн

боловсруулах санал ажлын хэсэг гаргаж байгаа учраас гүйцээн боловсруулах чиглэлийг ажлын хэсэг, Байнгын хороонд өглөө.

56.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “мэргэжлийн хяналтын” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 103 гишүүн оролцож, 60 гишүүн буюу 58,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын “Хишиг” сургуулийн 9^а, 9^б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Төрийн ордонтой танилцаж байгаа сургагч хүүхдүүддээ энэ өдрийн мэндийг хүргэж, сурлагын өндөр амжилт, хамгийн сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. Эрдэм номдоо шамдан суралцаж, удахгүй анги дэвших шалгалтаа амжилттай өгцгөөгөөрэй. Аав ээждээ тустай үеийн найзуудтайгаа бас эв эетэй, нэгнээ дээрэлхэгдэхгүй, хуулиа дээдэлдэг бас шударга иргэн болцгоогоорой. Амьдралд нь аз жаргал хүсье. Онц сураарай.

57.Төслийн 27 дугаар зүйлийн гарчгийн “Цусны донорын үйл ажиллагааны журмыг зөрчигчдөд” гэснийг “хууль зөрчигчид” гэж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийн “холбогдох” гэснийг “Төрийн албаны тухай” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 27.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 64 гишүүн буюу 62,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

58.Төслийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсгийг хасаж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 28.1 дэх хэсгийг нэмэх:

“28.1.Энэ хуулийн 6.1.6, 8.1.5, 9.4, 13.6-д заасан албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэлтэй холбоотой хэсэг, заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүн 61 гишүүн буюу 59,2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

59.Төслийн 29 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 60 гишүүн буюу 58,3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

60.Төсөлд зүйл, хэсэг, заалт хасах, нэмэх саналтай уялдуулан холбогдох зүйл, хэсэг заалтын дугаарлалт болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх, төслийн үг хэллэг, дэс дараалал, нэр томъёог жигдлэх засварыг хийх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 66 гишүүн буюу 64,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Цусны донорын тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. 103 гишүүнээс 64 гишүүн буюу 62,1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хоёр.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1.Хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 103 гишүүнээс 60 гишүүн буюу 58,3 хувийн саналаар дэмжигдлээ. Андуурч харсан байна. Энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудаар санал хурааж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн холбогдох хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаах тухай Байнгын хорооноос бэлтгэсэн зарчмын зөрөөтэй санал дэмжигдсэн.

Гишүүд ээ, одоо хоёрхон асуудал байгаа. Хоёрхон асуудлаа хэлэлцэж дуусаад, үдээс өмнөдөө багтаад завсарлачихъя. 2 асуудал байгаа. Нэг их том асуудал биш. Асуулт, үг бараг байхгүй.

Донорын тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хуулийн төслүүдийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол батлагдсанд тооцлоо.

Цусны донорын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Ажлын хэсэгт баярлалаа. Хууль санаачилсан гишүүддээ баярлалаа. Ажлын хэсэг ахалж ажилласан ялангуяа манай Жадамбаагийн Баясгалан гишүүн маань бас нэлээн анхаарч ажилласан байна. Баярлалаа.

12.58 цаг.

Дараагийн асуудалдаа орьё.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

О.Мөнхсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн 03 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалагч, Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, илтгэгч Э.Энхтуяа, Ц.Цолмон, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн А.Болор, Э.Сувд нар оролцлоо. Энэхүү хуралдаанаар Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлт нь нийт 15 хуудас, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 8 хуудас учраас дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл.

Энэхүү маргааны зүйл нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай гарсан шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд уг хуулийг буцаан хэрэглэхээр заасан нь Үндсэн хуулийг зөрчсөн эсэх асуудал байна. Хуулийг буцаан хэрэглэхгүй байх болон хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэх нь Эрүүгийн эрх зүйд хамаарах Үндсэн хуулийн зарчим тул эдгээрийн агуулга, Үндсэн хуулийн үндэслэл, үйлчлэх хүрээг тайлбарласны үндсэн дээр Зөрчлийн тухай хуульд үйлчлэх эсэх, Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг шалгана.

Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” гэж зааж, багтаамжийн хувьд ардчилсан эрх зүйт төр, Үндсэн хуульд ёсны үнэт зүйлсийг өргөн агуулгаар хамгаалсан байна. Тухайлбал, хууль дээдлэх ёсны дагуу зөвхөн хуулиар гэмт хэргийг тодорхойлж, ялыг тогтоох тул Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчмыг баримтална. Энэ зарчим нь үйлдэл, эс үйлдэхүй гарахын үеийн хуулиар гэмт хэрэгт тооцоогүй байсан бол түүний төлөө хэнийг ч гэмт хэрэгт буруутгахыг эсвэл гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял оногдуулахыг хориглох утгатай.

Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “тэгш байдал болон шударга ёсонд хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэх зарчим” багтаж хамгаалагдана. Энэ зарчмын дагуу гэмт хэрэг үйлдэх үед хүчин төгөлдөр үйлчилж байсан хууль болон шүүхийн эцсийн шийдвэр гарахын өмнө батлагдсан дараагийн хууль хооронд ял шийтгэлийн зөрүү байвал шүүх шүүгдэгчид илүү ашигтай хуулийг хэрэглэх үүрэгтэй.

Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэхгүй байх болон хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан заавал дагаж мөрдөх туйлын шинжтэй зарчим тул гэмт хэрэгт буруутгагдсан хэн бүхэн эдгээр зарчмын дагуу шүүлгэх үндсэн эрхтэй. Түүнчлэн эдгээр зарчим нь гэмт хэрэг болон холбогдох ялыг тодорхойлсон материаллаг эрх зүйд үйлчлэгч процессын эрх зүйд үйлчлэхгүй.

Хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчим нь захиргааны болон хувийн эрх зүйд үйлчлэх боловч эрүүгийн эрх зүй шиг туйлын шинжтэй биш. Өөрөөр хэлбэл эрүүгээс бусад салбар эрх зүйн хувьд хууль тогтоогч хууль ёсны зорилгыг хангах үүднээс үргэлжилж буй эрх зүйн харилцаанд холбогдох хуулийг буцаан хэрэглэхээр тухайлан хуульчилж болох ч энэ нь тохирсон байх зарчимд нийцэх ёстой. Хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэх зарчим нь эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим бөгөөд бусад салбар эрх зүйн хувьд гагцхүү эрүүгийн эрх зүйтэй төстэй зохицуулалтад хамаатай. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн дагуу оногдуулах захиргааны шийтгэл, албадлагын арга хэмжээ нь зөрчил үйлдэгчийг шийтгэж цээрлүүлэх шинжтэй тул энэ зарчим үйлчилнэ. Учир нь хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэх зарчим нь адил үйлдэл, эс үйлдэхүйд ял шийтгэл оногдуулахад тэгш тохирсон байдлаар хандах шаардлагаас урган гарна.

Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт хуулийг буцаан хэрэглэхгүй байх зарчмыг заасан бол мөн зүйлийн 4 дэх хэсэгт хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэх зарчмыг хуульчилжээ. Уг хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг буюу маргаан бүхий зохицуулалтад 2 тусдаа агуулга тусгагдсан байна.

Нэгд, тус зохицуулалтаар шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээг хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгэсэн бол эрх зүйн байдлыг дээрдүүлсэн буюу хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэхгүй болохыг тодруулж нэг мөр болгожээ. Энэ нь эрх зүйн тодорхой байдлыг хангах замаар хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

Хоёрт, Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээг хэрэглэх шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд буцаан хэрэглэнэ гэж заасан нь хууль тогтоох онцгой бүрэн эрхийн асуудал байх тул Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Үндсэн хуулиар хамгаалагдсан хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэх зарчим нь үйлдэл, эс үйлдэхүй гарсны дараа батлагдсан хуулиар түүнийг зөрчилд тооцохгүй болсон, эсвэл оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн бол шийдвэр гаргах үед тухайн хуулийг буцаан хэрэглэхийг үүрэгжүүлнэ.

Харин хүчин төгөлдөр болсон шийдвэрийг гүйцэтгээгүй тохиолдолд хөнгөрүүлсэн хуулийг буцаан хэрэглэхийг Үндсэн хуулиар шаардаагүй байна. Холбогдох шүүхийн шийдвэрээс харахад маргаан бүхий заалтыг шүүх ялгаатай хэрэглэж байх боловч Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлах хэрэглэх нь ердийн шүүхийн эрх хэмжээнд хамаарна. Иргэний өргөдлөөр тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр өөрийнх нь үндсэн эрхийг зөрчсөн тухай маргааныг үүсгэснээс бусад тохиолдолд Үндсэн хуулийн цэц үүнийг хянаж шийдвэрлэхгүй.

Энэ маргааны хувьд иргэд мэдээлэл гаргасан байх бөгөөд үндсэн эрхийг нь хөндөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан

шийдвэрлэх тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

1.Зөрчлийн тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгэсэн бол хуулийг буцаан хэрэглэхгүй ба шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд буцаан хэрэглэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” мөн, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчөөгүй байна.

2.Энэхүү дүгнэлтийг Улсын Их Хуралд уламжилсугай. Даргалагч Г.Баясгалан, гишүүд О.Мөнхсайхан, Э.Энхтуяа, Ц.Цолмон, Б.Болдбаатар.

Анхаарал хандуулсан баярлалаа.

С.Бямбацогт: Асуудлаа хэлэлцээд дуусгая гээд түрүүн шийдсэн байгаа. Ингээд Улсын Их Хурлын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбогдуулан тухайн асуудалд томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 03 дугаар дүгнэлттэй танилцлаа.

13.07 цаг.

Дараагийн асуудалдаа орьё.

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Анар танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ч.Анар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.9 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2026 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

2026-ны 04 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2026 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсөн болно.

Монгол Улсын Их Хурлын даргад Монгол Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 128 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэгийг Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд оруулах санал ирүүлснийг тус Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 72,2 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Анар гишүүнд баярлалаа. Дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулах ёстой.

Танхимд санал хураалтын ирц хангалтгүй байгаа учраас санал хураалтыг Баасан гаргийн 10 цагаас болгож хойшлууллаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Өглөө чуулганы хуралдаандаа хүрэлцэн ирсэн 103 гишүүндээ баярлалаа. Тэн дундаас сая санал хураалтад оролцсон 68 гишүүндээ илүү их талархлаа. Баярлалаа та бүхэндээ. Огт гарахгүй суусан манай Баттулга гишүүн, Лодойсамбуу гишүүд бол өнөөдөр суудлаасаа ерөөсөө өндийсөнгүй. Ариунзаяа гишүүд нар маань. Өглөө 10 цагаас хойш тасралтгүй суусан байна. Баярлалаа. Манай Ганмаа гишүүн, Саранчулуун гишүүн бас яг тасралтгүй суусан. Баярлалаа.

Өнөөдрийн чуулганы үйл ажиллагаа хаасныг мэдэгдье.

13.09 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ